

Тайлан бэлтгэсэн:	АГУУЛГА	
Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Н.Цэвэлмаа	1 АУДИТЫН ДҮГНЭЛТ	5
Санхүүгийн аудитын газрын аудитын менежер:	2 АУДИТ ХИЙСЭН ЗАСГИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН	7
С.Нацагдорж	2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН	7
А.Цогбаяр	2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	8
Э.Энхбаатар	2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	9
	2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	10
Ахлах аудитор:	3 АУДИТЫН ТАЙЛАН	12
Г.Оюунтөгөлдөр	3.1 ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	12
Э.Бат-Эрдэнэ	3.2 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	13
Ж.Бүжинханд	4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР	14
О.Баярмаа	4.1 Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	14
П.Батцэцэг	4.2 Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	14
Б.Лхагвацэнд	4.3 Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
Б.Ариунжаргал	4.4 Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
Аудитор:	4.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн давхардсан ажил, гүйлгээний устгах бичилт	15
Б.Батхишиг	4.6 Засгийн газрын болон төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн алдаа, залруулга	15
Д.Батчимэг	5 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	17
Г.Өсөхжаргал	5.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	17
С.Алтанхуяг	5.2 БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	22
С.Болортуяа	5.3 АВЛАГА	23
Д.Номингуа	5.4 УРЬДЧИЛГАА	29
Ж.Бямбацогт	5.5 БАРАА МАТЕРИАЛ	30
Ч.Мөнхбулган	5.6 НӨӨЦИЙН БАРАА	31
Г.Сампилмаа	5.7 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	32
2026 оны 6 дугаар сар	5.8 УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	32
Уг тайланг УАГ-ын Цахим хуудаснаас үзнэ үү: www.audit.mn	5.9 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	33
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261663 дугаар утсаар харилцана уу.	5.10 ӨР ТӨЛБӨР	34
ХАЯГ:	5.11 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО	40
Үндэсний аудитын газар	6. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АСУУДЛААРХ ИЛРҮҮЛЭЛТ	41
Засгийн газрын IV байр,	7. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	42
Бага тойруу-6,	7.1 ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	42
Улаанбаатар-46	7.2 ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	43
Монгол Улс	7.3 ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСЛҮҮДИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	46
	7.4 ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	47
	7.5 ӨМНӨХ АУДИТЫН МӨРӨӨР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН	48
	8. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	49

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АЗЗА	Авто зам, засвар арчлалт
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
АҮЭБС	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд
БЗС	Боловсролын зээлийн сан
БОУАӨС	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд
БС	Боловсролын сайд
ГБХНХС	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ГХС	Гадаад харилцааны сайд
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЕСБХБ	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан
ЖДҮДТ	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв
ЗГСНТ	Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТС	Зам тээврийн сайд
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
МУДШЕШ	Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч
МУЕС	Монгол Улсын Ерөнхий сайд
МУИС	Монгол Улсын Их сургууль
МУШСОБХАЭ	Монгол Улсын Шадар сайд Онцгой байдал, бүсчилсэн хөгжлийн асуудал эрхэлсэн
МУТШСБЭЗХС	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд
МУҮХЦД	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга
МЦХ	Монголын цахилгаан холбоо
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДС	Нийгмийн даатгалын сан
НДҮЗД	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга
НОСК	Нийслэлийн орон сууцны корпорац
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНТЕЗ	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч
ОУХНЦ	Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
СС	Сангийн сайд
ССАЖЗС	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТОСК	Төрийн орон сууцны корпорац
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УАӨСХА	Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа хамтын ажиллагааны төв
УБЦТС	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ
УИХ	Улсын Их Хурал

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УТЕЗ	Улсын төсвийн ерөнхийлөн захирагч
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчин
ҮЦК	Үнэт цаасны компани
ХААГ	Хөдөө аж ахуйн газар
ХББОСС	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд
ХБХХЕГ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
ХГБХХХ	Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын хэлтэс
ХГБХХЕГ	Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын ерөнхий газар
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХК	Хувьцаат компани
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЭҮКД	Хүний эрхийн үндэсний комиссын дарга
ЦАУЗБУКД	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын дарга
ЦХИХХС	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ЭЗХАБХТ	Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн төслийг хөгжүүлэх төсөл
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭХС	Эрчим хүчний сайд



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.06.10 № 1433
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг, хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан, дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн шийдвэр болон “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын санхүүжилтийн гэрээ” - ний дагуу төслийн санхүүжилтийг хувьцаанд хөрвүүлэхээр зохицуулсан ч нийт 3,283.9 тэрбум төгрөгийн санхүүжилтээс 1,937.2 тэрбум төгрөгийг хөрвүүлээгүй, урьдчилгаа дансанд үлдэгдлээр бүртгэсэн;
- Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн Чингис хаан банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байгаа мөнгөн хөрөнгийн үлдэгдэл болон “Капитал банк” ХХК дахь эрх хүлээн авагчаас авах нийт 376.6 тэрбум төгрөгийн авлагаас 132.3 тэрбум төгрөгийг барагдуулж, 244.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй, 61.4 тэрбум төгрөгийн хөрөнгийн борлуулах үйл ажиллагаа удаашралтай;

- Төсвийн зарлагын эх үүсвэрийг нөхөж өглөг үүсгэсэн дүнг өмнөх оноос 193.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг бууруулж тайлагнасан;
- Зээлийн эргэн төлөлт хангалтгүй, тооцоо нийлэх боломжгүй, шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болсон нийт 466.0 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа зэрэг нь санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын багцад нэгтгэгдэж байсан Эрдэнэс Монгол ХХК болон түүний хараат, охин компаниудын 2025 оны санхүүгийн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тайланд нэгтгэн толилуулсан байна.

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн зорилт 4-т “Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна” гэж заасны дагуу тайлант онд 148.7 тэрбум төгрөгийн үнэт цаасыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар дамжуулан арилжаалсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газар тайлант онд 9,109.5 тэрбум төгрөгийн ашиглаагүй зээлийн үлдэгдэлд 37.6 тэрбум төгрөгийн амлалтын хүү төлсөн байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар тогтоолд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эрх бүхий этгээд ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн орлогоос “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэнэс Монгол” ХХК, түүний нэгдлийн болон бусад төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд хооронд үүссэн өр авлагад суутган тооцохоор тогтоосон ч хэрэгжилт хангагдаагүй, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн санхүүгийн тайланд 2022-2023 оны төрд ногдох ногдол ашгийн 3,305.2 тэрбум төгрөгийн урт хугацаат өр төлбөр бүртгэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Бидний дүгнэлтэд нөлөөлөхгүйгээр дараах асуудлыг хэрэглэгчдийн анхааралд хүргэж байна.

Монгол Улсын зээлжих зэрэглэл тайлант онд нэмэгдэж Эс энд Пи агентлагаас В+ эерэг байсныг ВВ- тогтвортой түвшинд, Мүүдиз агентлагаас В2 байсныг В1, тогтвортой түвшинд хүргэж, Фитч агентлагаас В+, тогтвортой түвшинд хэвээр хадгалж, зээлийн эрсдэлийн үнэлгээг нэг шат ахиулсан байна.

Тайлант онд Сенчири-4 бондыг олон улсын зах зээлд 500.0 сая ам.доллар буюу 1,731.5 тэрбум төгрөгөөр арилжаалж, Номад бондоос 391.7 сая ам.доллар буюу 1,356.6 тэрбум төгрөг, Сенчири-2 бондоос 108.3 сая ам.доллар буюу 374.9 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний үнэт цаасыг дахин санхүүжүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Сангийн яам Монгол Улсын Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2 АУДИТ ХИЙСЭН ЗАСГИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Дансны код	Дансны нэр, төрөл	/мянган төгрөгөөр/	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	49,372,928,360.7	52,261,360,361.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	14,545,799,856.8	15,916,430,042.3
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	1,842,307,057.7	2,022,626,649.2
33	АВЛАГА	6,811,689,606.3	7,606,118,313.8
34	УРЬДЧИЛГАА	5,891,559,868.9	3,902,442,311.6
35	БАРАА МАТЕРИАЛ	4,262,438,394.5	4,675,006,178.2
36	НӨӨЦИЙН БАРАА	262,209,470.4	244,206,225.2
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	15,756,924,106.1	17,894,530,640.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	72,865,145,012.5	81,202,255,193.1
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	13,291,996,604.4	13,456,229,393.9
37100	Урт хугацаат хадгаламж	57,967,999.0	62,618,443.0
37200	Үнэт цаас	2,659,976,425.7	2,342,338,051.6
37300	Урт хугацаат зээл	10,574,052,179.7	11,051,272,899.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	59,573,148,408.1	67,746,025,799.2
39100	Газар	46,095,332.2	46,095,332.2
39200	Биет хөрөнгө	34,670,430,787.6	42,465,628,932.7
39300	Биет бус хөрөнгө	19,600,156,055.5	21,186,442,287.0
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	5,256,466,232.8	4,047,859,247.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	122,238,073,373.2	133,463,615,554.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	57,724,001,648.7	61,094,215,887.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	13,317,636,121.3	14,414,516,463.4
41100	Богино хугацаат үнэт цаас	10,044,464.2	138,956,769.9
41200	Богино хугацаат зээлийн өглөг	3,653,406,208.7	3,211,038,810.0
41300	Өглөг	6,639,710,951.9	7,540,650,579.2
41400	Урьдчилж орсон орлого	3,014,474,496.5	3,523,870,304.2
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	44,406,365,527.4	46,679,699,424.3
42100	Урт хугацаат үнэт цаас	15,560,012,015.6	15,763,011,515.7
42200	Урт хугацаат зээл	28,846,353,511.8	30,916,687,908.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	64,514,071,724.5	72,369,399,666.4
51	Засгийн газрын хувь оролцоо	64,498,608,527.6	72,353,944,047.8
51100	Засгийн газрын оруулсан капитал	7,867,789,183.3	9,539,132,912.3
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	7,548,982,568.4	8,136,250,107.0
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/	15,495,693.0	15,503,271.3
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	11,256,095,009.3	11,256,095,009.4
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	18,396,486.3	18,563,732.3
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	10,063,086,010.1	10,747,368,692.6
51200	Хуримтлагдсан үр дүн	20,063,740,822.3	24,388,554,506.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,510,105,807.9	8,098,372,986.2
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	154,699,287.1	153,830,231.0
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	217,659.9	272,599.1
52	Хяналтын бус хувь оролцоо	15,463,196.9	15,455,618.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	122,238,073,373.2	133,463,615,554.1

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	56,004,733,843.7	52,257,897,198.5
1010	ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН	-	2,313,562,737.5
1020	ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	-	562,490,767.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	28,609,895,207.6	26,612,606,859.7
110	Орлогын албан татвар	9,114,948,948.2	8,561,670,160.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	2,630,433,367.1	2,988,435,177.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(78,897,501.5)	(92,124,833.7)
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	10,148.6	10,189.9
1103	ААН-ын орлогын албан татвар	6,563,402,934.0	5,665,349,627.1
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	4,774,274,408.3	5,180,423,423.1
113	Хөрөнгийн албан татвар	459,508,615.1	609,831,335.0
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	5,843,603,928.3	6,206,058,410.5
115	Онцгой албан татвар	1,098,207,320.2	947,243,365.5
116	Тусгай зориулалтын орлого	26,427,609.4	25,498,438.5
117	Гадаад үйл ажиллагааны орлого	1,792,591,942.3	1,842,078,091.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	5,500,332,435.8	3,239,803,635.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,801,347,073.5	22,483,935,081.8
120	Нийтлэг татварын бус орлого	26,054,350,084.7	21,124,849,292.9
121	Хөрөнгийн орлого	172,380,867.7	20,377,588.5
122	Тусламжийн орлого	555,765,924.7	1,256,682,051.1
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	1,333,086.7
124	Зээлийн орлого	18,850,196.4	80,693,062.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	593,491,562.6	285,301,751.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	35,164,266,044.3	37,971,126,505.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	35,088,288,689.9	37,168,103,180.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,707,900,940.6	23,750,648,278.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,077,250,149.7	8,585,730,796.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	744,182,818.7	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	592,485,853.3	730,071,786.3
2104	Хангамж, бараа материалын зардал	967,852,839.2	771,151,470.3
2105	Нормативт зардал	807,223,893.6	879,208,240.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	203,360,256.6	242,095,346.8
2107	Томилолт, зочны зардал	148,940,012.5	157,888,226.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,239,320,862.1	8,170,745,770.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,927,284,254.9	4,213,756,642.3
211	ХҮҮ	1,763,746,352.2	2,444,260,557.4
212	ТАТААС	827,351,602.4	1,161,499,755.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,789,289,794.7	9,811,694,588.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	75,977,354.4	803,023,324.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	20,840,467,799.4	14,286,770,692.9
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	6,833,821,515.8	5,662,195,109.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,337,583,356.9	11,381,959,127.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	17,336,705,958.3	8,567,006,674.1

2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Данс ны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	51,516,330,368.6	-	51,516,330,368.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	834,319,916.5	-	834,319,916.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,350,650,285.1	-	52,350,650,285.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	13,536,984.3	-	13,536,984.3
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	71,666,831.3	-	71,666,831.3
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	(2,151,144.2)	-	(2,151,144.2)
7	Өмчид гарсан өөрчлөлт	(98,013,329.6)	-	(98,013,329.6)
8	Зарласан ногдол ашиг	(5,158,323,860.6)	-	(5,158,323,860.6)
9	Тайлант үеийн үр дүн	17,336,705,958.3	-	17,336,705,958.3
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	64,514,071,724.5	-	64,514,071,724.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	750,054,718.1	-	750,054,718.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	65,264,126,442.6	-	65,264,126,442.6
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	659,379,822.6	-	659,379,822.6
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,967,935,653.4	-	1,967,935,653.4
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	(528,728,241.7)	-	(528,728,241.7)
17	Өмчид гарсан өөрчлөлт	1,137,173,011.5	-	1,137,173,011.5
18	Зарласан ногдол ашиг	(4,697,493,696.2)	-	(4,697,493,696.2)
19	Тайлант үеийн үр дүн	8,567,006,674.1	-	8,567,006,674.1
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	72,369,399,666.4	-	72,369,399,666.4

2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	80,088,231,655.8	66,911,570,690.3
1010	ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН	-	1,390,316,595.4
1020	ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	-	514,883,023.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	28,805,773,488.3	26,571,761,231.6
110	Орлогын албан татвар	9,114,511,659.6	8,560,377,564.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	2,629,996,078.5	2,987,534,689.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(78,897,501.5)	(92,124,833.7)
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	10,148.6	10,189.9
1103	ААН-ын орлогын албан татвар	6,563,402,934.0	5,664,957,518.7
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	5,149,605,490.0	4,711,119,979.6
113	Хөрөнгийн албан татвар	459,452,695.5	609,776,673.2
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	5,863,600,982.3	6,207,344,295.9
115	Онцгой албан татвар	1,098,932,420.3	947,420,972.6
116	Тусгай зориулалтын орлого	26,427,609.4	25,498,438.5
117	Гадаад үйл ажиллагааны орлого	1,792,341,760.2	1,842,195,348.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	5,300,900,871.0	3,668,027,959.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,909,296,718.4	3,284,717,448.0
1181	Газрын төлбөр	239,016,402.1	222,968,898.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	121,881,019.7	121,404,080.5
1183	Бусад татвар	30,706,730.8	38,937,532.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,630,134,322.6	38,149,308,088.2
120	Нийтлэг татварын бус орлого	50,528,101,382.4	37,215,833,524.4
121	Хөрөнгийн орлого	6,832,631.8	11,780,843.3
122	Тусламжийн орлого	95,200,308.4	921,543,147.1
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	150,573.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	652,323,844.9	285,301,751.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	67,162,596,187.7	56,479,097,933.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	67,162,596,187.7	56,479,097,933.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,226,188,703.3	42,171,060,651.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,910,200,894.9	10,828,638,894.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,270,983,118.5	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,152,008,600.6	957,392,290.9
2104	Хангамж, бараа материалын зардал	6,170,585,253.2	8,311,778,326.5
2105	Нормативт зардал	736,087,186.1	836,843,439.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	263,416,937.4	293,521,284.6
2107	Томилолт, зочны зардал	145,615,220.5	152,496,749.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,390,150,600.9	19,168,787,348.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,187,140,891.2	1,621,602,318.6
211	ХҮҮ	1,800,008,843.4	2,349,764,975.8
212	ТАТААС	686,109,231.0	504,978,749.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,450,289,410.0	11,453,293,556.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	12,925,635,468.1	10,432,472,757.3
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	18,332,010,314.5	20,440,542,224.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	27,263,741,028.8	28,520,404,684.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,263,741,028.8	28,520,404,684.5
2200	Дотоод эх үүсвэрээр	27,261,227,951.7	28,518,597,141.8

3 АУДИТЫН ТАЙЛАН

3.1 ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аудит хийсэн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасныг тус тус үндэслэн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС, СТОУС, НББОУС, санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцүүлэн үнэн зөв илэрхийлсэн эсэхэд дүгнэлт гаргаж, үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгуудад Аудитын олон улсын стандарт, Төрийн аудит MNS 6817-4:2020 Санхүүгийн аудитын тулгуур зарчимд заасны дагуу аудитын горим, сорилыг төлөвлөж, хэрэгжүүлсэн.

Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт гаргахын өмнө Төрийн аудитын тухай болон Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, төсөл, хөтөлбөр, сан, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

Аудитын арга зүй

Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг үндсэн шалгуур болгон хяналтын сорил, шинжилгээний горим гүйцэтгэж, түүврээр ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж үнэлгээ өгөв.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэл, мөн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэл зэрэг асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг тайланд тусгасан.

Материаллаг байдлын түвшин

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн байгууллага, төрийн сан, төсөл, хөтөлбөр, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгтгэсэн тул материаллаг байдлын түвшнийг төлөвлөлтийн үе шатанд Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 45,501.8 тэрбум төгрөгийн 1.0 хувь буюу 455.0 тэрбум төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

3.2 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улсын секторын дотоод аудитын бүтэц, орон тоог 2025 оны байдлаар авч үзэхэд нийт 60 ТЕЗ-аас 47, 38 ТТЗ-аас 9 нь дотоод аудитын нэгжтэй, нийт 303 дотоод аудитор ажиллаж байна.

Сангийн яамны Дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалт үнэлгээний газар нь дотоод аудитын чиг үүргийн хүрээнд төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалт хийх, дүгнэлт, зөвлөмжөөр хангах, ТЕЗ-дын дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүрэгтэй. Эдгээр чиг үүргийн хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

- ТЕЗ-дын дотоод аудитын нэгжийг стандарт, мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүргийн хүрээнд 2025 оны байдлаар нийт 59 байгууллагын давхардсан тоогоор 605 улсын секторын аудиторуудад сургалт зохион байгуулсан байна.
- Тайлант оны батлагдсан төлөвлөгөөгөөр 11 байгууллагад хяналт шалгалт хийхээс төлөвлөгөөт 11, төлөвлөгөөт бус 6 нийт 17 байгууллагын үйл ажиллагаанд сэдэвчилсэн хяналт шалгалт хийсэн байна.
- Дотоод аудитын нэгжүүдийн 2023, 2024 оны үйл ажиллагаанд Дотоод аудитын олон улсын стандарт, ёс зүйн дүрэм, холбогдох журмын дагуу дотоод аудитыг гүйцэтгэсэн эсэхэд хараат бусаар хөндлөнгийн үнэлгээ хийж, Нийслэл, дүүргийн Засаг дарга нарт 3, дотоод аудитын албадад 7 зөвлөмжийг тус тус өгсөн байна.

ТЕЗ-дын дотоод аудитын нэгжүүд харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчилд дүн шинжилгээ хийж, давтан гаргахаас урьдчилан сэргийлэх, залруулах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс өмнөх онтой харьцуулахад зөрчлийн дүн буураагүй байна.

4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

Сангийн яам Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх заалтын дагуу Монгол Улсын Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн, хуулийн хугацаанд Үндэсний аудитын газарт ирүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Сангийн яамны Finperform системээр нэгтгэн гаргасан байна.

Finperform системийг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/231 дүгээр тушаалаар нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, тайлант оноос Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэж эхэлсэн байна.

Тус систем нь төрийн байгууллагуудын санхүүгийн мэдээллийг нэгдсэн байдлаар хүлээн авах, нэгтгэн боловсруулах, тайлагнах, хяналт хэрэгжүүлэх, тайлан хоорондын уялдаа холбоог сайжруулах, нэгдсэн нэвтрэлтийн системээр бусад системүүдтэй холбогдож мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлжээ.

4.1 Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгийн дүн 133,463.6 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 11,225.5 тэрбум төгрөгөөр өссөн байна

Хүснэгт 1. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Эргэлтийн хөрөнгийн дүн	49,372,928.4	52,261,360.4	2,888,432.0	39.2
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	72,865,145.0	81,202,255.2	8,337,110.2	60.8
Нийт хөрөнгийн дүн	122,238,073.4	133,463,615.6	11,225,542.2	100.0
Нийт өр төлбөр	57,724,001.7	61,094,215.9	3,370,214.2	45.8
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	64,514,071.7	72,369,399.7	7,855,328.0	54.2
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	122,238,073.4	133,463,615.6	11,225,542.2	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 9.2 хувиар өссөн байна. Үүнээс эргэлтийн хөрөнгө 2,888.4 тэрбум төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 8,337.1 тэрбум төгрөг, нийт өр төлбөр 3,370.2 тэрбум төгрөг, цэвэр хөрөнгө/өмч 7,855.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгджээ.

4.2 Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт үр дүн 8,567.0 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 50.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

Хүснэгт 2. Нийт үйл ажиллагааны үр дүн

Байгууллагын төрөл	Өмнөх он	Тайлант он	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сан	22,504,533.7	20,442,860.7	(2,061,673.0)
Төсөвт байгууллага	(16,901,095.6)	(18,022,768.6)	(1,121,673.0)
Төрийн өмчит компани	8,504,385.8	3,753,788.0	(4,750,597.8)
Төсөл/сан	3,228,882.1	2,393,126.6	(835,755.5)
Нийт үр дүн	17,336,706.0	8,567,006.7	(8,769,699.3)

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны үр дүн нийт 3,753.8 тэрбум төгрөгийн ашигтай, төсөл, сангууд 2,393.1 тэрбум төгрөг, төрийн сан 20,442.9 тэрбум төгрөгийн эерэг үр дүнтэй¹;

¹ орлого нь зардлаасаа их

Төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн нийт 18,022.8 тэрбум төгрөгийн сөрөг үр дүнтэй² гарсан байна.

4.3 Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангаар Засгийн газрын хувь оролцоо 7,855.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн үр дүн 8,769.7 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

4.4 Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд нийт мөнгөн орлого 93,844.9 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 11,730.7 тэрбум төгрөгөөр, нийт мөнгөн зарлага 92,474.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 10,646.5 тэрбум төгрөгөөр тус тус буурсан, нийт цэвэр мөнгөн гүйлгээ 1,370.6 тэрбум төгрөгийн үзүүлэлттэй илэрхийлэгдэж, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 15,916.4 тэрбум төгрөг байна.

4.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн давхардсан ажил, гүйлгээний устгах бичилт

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нэгтгэлд хамрагдсан байгууллагуудын хооронд үүссэн өр төлбөр, авлага, орлого, зардлын давхардсан ажил, гүйлгээг санхүүгийн байдлын тайланд 26,028.1 тэрбум төгрөгөөр, санхүүгийн үр дүнгийн тайланд 59,022.6 тэрбум төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд 63,031.6 тэрбум төгрөгөөр тус тус устгах бичилт хийсэн байна.

4.6 Засгийн газрын болон төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн алдаа, залруулга

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 5,093.4 тэрбум төгрөгийн 6,528 алдаа илэрснээс 4,823.3 тэрбум төгрөгийн 6,472 алдааг залруулж, 18.7 тэрбум төгрөгийн 7 алдаанд 4 албан шаардлага, 251.4 тэрбум төгрөгийн 49 алдааг залруулга хийх зөвлөмж өгсөн.

4.6.1 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын алдаа, залруулга

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 4,097.4 тэрбум төгрөгийн 4,269 алдаа илэрснээс 3,827.7 тэрбум төгрөгийн 4,218 алдааг залруулж, 18.7 тэрбум төгрөгийг 7 алдаанд 4 албан шаардлага, 251.0 тэрбум төгрөгийн 44 алдааг залруулах зөвлөмж өгсөн.

4.6.2 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын алдаа, залруулга

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой 981.2 тэрбум төгрөгийн 2,253 алдаа илэрснээс нийт 981.2 тэрбум төгрөгийн 2,249 алдааг залруулж, 4 алдааг залруулах зөвлөмж өгсөн.

4.6.3 Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, залруулга

Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт 14.8 тэрбум төгрөгийн 6 алдаа илэрснээс 14.4 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 0.4 тэрбум төгрөгийн залруулаагүй алдаанд 1 зөвлөмж өглөө. Үүнд:

Залруулсан алдаа:

- Арилжааны банк дахь төгрөгийн дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2.3 тэрбум төгрөг, “Улаанбаатар дулааны тавдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 0.2 тэрбум төгрөг, нийт 2.5 тэрбум төгрөгийг кассын дансны үлдэгдлээр ангилал зөрүүтэй тайлагнасан;

² орлого нь зардлаасаа бага

- Удирдлагын академи болон Засгийн газрын байруудын ашиглалтын нэгдсэн захиргааны хадгаламжийн дансны 10.8 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг арилжааны банкин дахь төгрөгийн дансны үлдэгдлээр ангилал зөрүүтэй тайлагнасан;
- “Эрчис ойл” ХХК-ийн арилжааны банканд байршуулсан гадаад төлбөр тооцооны валютын дансны 0.1 тэрбум төгрөгийн үлдэгдлийг төгрөгийн дансны үлдэгдлээр ангилал зөрүүтэй тайлагнасан;
- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангийн эцсийн үлдэгдлээс 1.0 тэрбум төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангийн эхний үлдэгдлийг 0.06 тэрбум төгрөгөөр дутуу илэрхийлж тайлагнасан.

Залруулагдаагүй алдаа:

- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч болон “Митайм интернэйшнл” ХХК хооронд Дулааны тавдугаар цахилгаан станц төслийг хэрэгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулж, тус аж ахуйн нэгжээс төрийн сангийн дансанд байршуулсан барьцааны 0.4 тэрбум төгрөгийг санхүүгийн тайланд тайлагнаагүй.

Өгсөн зөвлөмж: Нийслэлийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгаагүй мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тайланд бүрэн тусгуулан, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үнэн зөв байдлыг хангах.

5 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**5.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ**

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 15,916.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 1,370.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Мөнгөн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	/сая төгрөгөөр/ Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	47,079.2	43,617.8	(3,461.4)	0.3
Банканд байгаа бэлэн мөнгө	12,127,963.0	7,291,529.4	(4,836,433.6)	45.8
Замд яваа мөнгөн хөрөнгө	363,218.3	58,537.7	(304,680.6)	0.4
Хадгаламж	2,007,539.4	8,522,745.1	6,515,205.7	53.5
Дүн	14,545,799.9	15,916,430.0	1,370,630.1	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр:</i>				
ТӨҮГ болон ОНӨҮГ	5,229,032.0	5,851,043.1	622,011.1	36.8
Төрийн сан	2,982,272.1	2,042,595.7	(939,676.4)	12.8
Төсөвт байгууллага	808,574.8	462,541.8	(346,033.0)	2.9
Төсөл/ сан	5,525,921.0	7,560,249.4	2,034,328.4	47.5
Дүн	14,545,799.9	15,916,430.0	1,370,630.1	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,370.6 тэрбум төгрөгөөр өсөхөд төсөл сангийн үлдэгдэл 2,034.3 тэрбум төгрөгөөр, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үлдэгдэл 622.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, төрийн сангийн үлдэгдэл 939.7 тэрбум төгрөгөөр, төсөвт байгууллагын үлдэгдэл 346.0 тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Касст байгаа 43.6 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 43.1 тэрбум төгрөг буюу 98.7 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн, 0.5 тэрбум төгрөг буюу 1.3 хувь нь төсөвт байгууллагын, 0.02 тэрбум төгрөг нь төсөл сангийн үлдэгдэл тус тус эзэлж байна.

Банканд байгаа 7,291.5 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө дансны үлдэгдлийн 4,520.2 тэрбум төгрөг нь төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн, 417.5 тэрбум төгрөг нь төрийн сангийн, 1,893.2 тэрбум төгрөг нь төсөл сангийн, 460.6 тэрбум төгрөг нь төсөвт байгууллагын үлдэгдэл байна.

Замд яваа 58.5 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн 57.6 тэрбум төгрөг буюу 98.5 хувь нь төрийн санд, 0.8 тэрбум төгрөг буюу 1.4 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн, 0.1 тэрбум төгрөг буюу 0.1 хувь нь төсөвт байгууллагын үлдэгдэл байна.

Хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 8,522.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 6,515.2 тэрбум төгрөгөөр буюу 4.2 дахин өссөн байна.

Хүснэгт 4. Хадгаламж дахь мөнгөн хөрөнгө

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	/сая төгрөгөөр/ Дүнд эзлэх хувь
Ирээдүйн өв сан	-	4,751,697.8	4,751,697.8	55.8
Нийслэлийн ЗДТГ	1,671,133.4	1,567,408.0	(103,725.4)	18.4
Монгол Улсын хөгжлийн банк ХХК	263,152.5	1,123,522.1	860,369.6	13.1
Нийгмийн даатгалын сан	-	915,307.1	915,307.1	10.7
Төрийн банк ХК	-	71,143.6	71,143.6	0.8
Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	17,000.0	24,276.0	7,276.0	0.3
Монгол Улсын Боловсролын их сургууль	15,000.0	20,362.8	5,362.8	0.2
Шинжлэх ухаан, технологийн их сургууль	11,575.5	17,273.6	5,698.1	0.2

Удирдлагын академи	7,508.7	8,565.4	1,056.7	0.1
Монгол Улсын их сургууль	12,734.1	6,327.4	(6,406.7)	0.1
Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	3,722.3	5,147.4	1,425.1	0.1
Монгол шуудан ХК	-	4,102.5	4,102.5	0.1
Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨҮГ	2,250.0	4,000.0	1,750.0	0.1
Засгийн газрын байруудын ашиглалтын нэгдсэн захиргаа ТӨААТҮГ	2,019.4	2,205.4	186.0	-
Хөдөө аж ахуйн хөдөөгийн хөгжил нэгж	1,360.0	1,360.0	-	-
Гүний ус	83.6	46.0	(37.6)	-
Дүн	2,007,539.5	8,522,745.1	6,515,205.6	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тайлант онд 6,515.2 тэрбум төгрөгөөр өсөхөд Ирээдүйн өв сан 4,751.7 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын сан 915.3 тэрбум төгрөг, “Монгол Улсын хөгжлийн банк” ХХК 860.4 тэрбум төгрөг, “Төрийн банк” ХК 71.1 тэрбум төгрөг, “Монгол шуудан” ХК 4.1 тэрбум төгрөгийн хадгаламжийг шинээр нээсэн нь голлон нөлөөлжээ.

Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 435.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 474.3 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Банканд байгаа бэлэн мөнгө	866,224.0	404,760.8	(461,463.2)	93.0
Төгрөг	58,712.3	41,009.1	(17,703.2)	-
Төрийн сан	42,339.2	33,405.8	(8,933.4)	-
Монгол банк	8,857.0	2,699.7	(6,157.3)	-
Арилжааны банк	7,516.1	4,903.6	(2,612.5)	-
Гадаад валют	807,511.7	363,751.7	(443,760.0)	-
Монгол банк	801,962.5	357,925.6	(444,036.9)	-
Арилжааны банк	5,549.2	5,826.1	276.9	-
Замд яваа мөнгөн хөрөнгө	43,486.8	30,609.4	(12,877.4)	7.0
Дүн	909,710.8	435,370.2	(474,340.6)	100.0

Эх сурвалж: Төв төрийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн нийт үлдэгдлээс банканд байгаа бэлэн мөнгө 404.8 тэрбум төгрөг буюу 93.0 хувь, замд яваа мөнгөн хөрөнгө 30.6 тэрбум төгрөг буюу 7.0 хувийг тус тус эзэлж байна.

Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгөд тайлант онд үйл ажиллагааны орлогоос 19,386.8 тэрбум төгрөг, зээлийн эргэн төлөлт, бусад эх үүсвэрээс 6,179.3 тэрбум төгрөг, гадаад валютын ханшийн зөрүүгийн олз 645.4 тэрбум төгрөгийг тус тус бүрдүүлж, өмнөх оны зарцуулагдаагүй үлдэгдэл 909.7 тэрбум төгрөг, нийт 27,121.2 тэрбум төгрөгийн эх үүсвэрээс урсгал зардалд 19,146.6 тэрбум төгрөг, эргэж төлөгдөх зээлд 5,075.4 тэрбум төгрөг, гадаад зээлийн үндсэн төлбөрт 1,426.3 тэрбум төгрөг, ханшийн зөрүүнд 645.4 тэрбум төгрөг, бусад зардалд 392.1 тэрбум төгрөг, нийт 26,685.8 тэрбум төгрөгийг зарцуулж, 435.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс тайлант онд хуваарилсан 131.7 тэрбум төгрөгийг Ирээдүйн өв сангийн дансанд төвлөрүүлээгүй, өглөгөөр тайлагнасан;
- Төсвийн зарлагын эх үүсвэрийг нөхөж өглөг үүсгэсэн дүнг өмнөх оноос 193.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг бууруулж тайлагнасан;
- Төрийн сангийн нэгдсэн дансанд 0.1 тэрбум төгрөгийн төвлөрүүлээгүй мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байршиж байна.

Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,255.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 825.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. НДС-ийн мөнгөн хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Банканд байгаа бэлэн мөнгө	1,430,750.8	1,340,525.4	(90,225.4)	100.0
Төгрөг	1,430,750.8	1,340,501.8	(90,249.0)	99.9
Төрийн сангийн харилцах	114,746.8	228,496.1	113,749.4	
Арилжааны банкны харилцах	1,100,696.9	1,112,005.7	11,308.8	
Бусад төсөл, нөөцийн харилцах	215,307.1	-	(215,307.1)	
Гадаад валют	-	23.6	23.6	0.1
Арилжааны банк дахь харилцах	-	23.6	23.6	-
Хадгаламж	-	915,307.1	915,307.1	-
Дүн	1,430,750.8	2,255,832.6	825,081.7	100.0
<i>Үүнээс, сангийн төрлөөр</i>				
Тэтгэврийн даатгалын сангийн харилцах	361,101.3	596,862.2	235,760.9	26.5
Тэтгэмжийн даатгалын сангийн харилцах	327,731.3	258,595.6	(69,135.7)	11.5
ҮОМШӨ-ний даатгалын сангийн харилцах	484,079.7	338,963.0	(145,116.7)	15.0
Ажилгүйдлийн даатгалын сангийн харилцах	4,167.4	2,854.6	(1,312.8)	0.1
Эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах	8,116.4	2.6	(8,113.8)	-
Төвлөрсөн харилцах	30,247.5	55,886.2	25,638.7	2.5
Нөөц сангийн харилцах	215,307.1	87,361.3	(127,945.8)	3.9
Хадгаламж	-	700,000.0	700,000.0	31.0
Хадгаламж/мөнгөжүүлсэн/		215,307.1	215,307.1	9.5
Дүн	1,430,750.8	2,255,832.6	825,081.7	100.0

Эх сурвалж: НДС-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 825.1 тэрбум төгрөгөөр өссөн нь дараах өөрчлөлтөөс голлон шалтгаалжээ. Тухайлбал:

- Улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792,000.00³ төгрөг болгон нэмэгдүүлсэн, даатгуулагчийн тоо 13,626 даатгуулагчаар нэмэгдсэн зэргээс шалтгаалан НДС-ийн орлого өмнөх оноос 1.2 дахин буюу 797.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн;
- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 07 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс банкны системд нөлөө бүхий арилжааны банканд хадгаламж хэлбэрээр байршуулах мөнгөн хөрөнгийн дээд хэмжээг 700.0 тэрбум төгрөгөөр тогтоосны дагуу “ХААН банк” ХК-д 289.7 тэрбум төгрөг, “Худалдаа хөгжлийн банк” ХК-д 176.2 тэрбум төгрөг, “Голомт банк” ХК-д 158.4 тэрбум төгрөг, “Төрийн банк” ХК-д 75.7 тэрбум төгрөгийг 1 жилийн хугацаатай 15.0-15.1 хувийн хүүтэй байршуулж, тайлант онд 70.3 тэрбум төгрөгийн хүүгийн өгөөжийг бүртгэсэн;
- Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1⁴ дэх заалтын дагуу тайлант онд нийгмийн даатгалын чөлөөт мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс “Худалдаа хөгжлийн банк” ХК, “ХААН банк” ХК, “Төрийн банк” ХК, “Голомт банк” ХК дахь тэтгэврийн нөөц сангийн харилцах дансанд 87.4 тэрбум төгрөгийг байршуулж, 7.3 тэрбум төгрөгийн хүүгийн өгөөжийг бүртгэсэн.

“Чингис хаан банк” ХХК-д байршиж буй мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 93.4 тэрбум төгрөг байснаас тайлант онд 4.1 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгөөр, 7.5 тэрбум төгрөгийн өртөгтэй 11 ширхэг оффис, орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгө, нийт 11.6 тэрбум төгрөгийг барагдуулж, 81.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

³ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 03 дугаар тогтоол Улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэг цагт 4,715 төгрөг буюу сард 792,000.00 төгрөг байхаар шинэчлэн тогтоосугай.

⁴ тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулж тэтгэврийн нөөц сантай

Аудитын илрүүлэлт:

- “Чингис хаан банк” ХХК-аас нэхэмжилсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 81.8 тэрбум төгрөгийн харилцах дансны үлдэгдэл төлөгдөөгүй эрсдэлтэй хэвээр байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 217.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 61.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. ЭМДС-ийн мөнгөн хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт +/- Бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	101,516.7	179,219.3	77,702.6	82.5
Арилжааны банкны харилцах	54,729.8	38,134.5	(16,595.3)	17.5
Нийт дүн	156,246.5	217,353.9	61,107.3	100.0
Төрийн сангийн харилцах	101,141.7	178,988.2	77,846.5	82.3
Нэмэлт санхүүжилтийн харилцах	375.0	231.1	(143.9)	0.1
ХААН банк	9,551.5	1,636.8	(7,914.7)	0.8
Капитрон банк	17.7	152.2	134.5	0.1
Төрийн банк ХК	1,070.3	1,106.9	36.6	0.5
Чингис хаан банк	30,575.7	26,828.6	(3,747.1)	12.3
Голомт банк	8,149.0	3,612.9	(4,536.1)	1.7
Хас банк	2,031.1	220.8	(1,810.3)	0.1
Худалдаа хөгжлийн банк	3,334.5	4,576.3	1,241.8	2.1
Нийт мөнгөн хөрөнгө	156,246.5	217,353.9	61,107.3	100.0

Эх сурвалж: ЭМДС-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ЭМДС-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 61.1 тэрбум төгрөгөөр өсөхөд төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 77.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 0.1 тэрбум төгрөгөөр, арилжааны банкин дахь үлдэгдэл 16.5 тэрбум төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна. Тухайлбал:

- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 03 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 792,000.00 төгрөг болгон нэмэгдүүлсэн болон ажил олгогч, даатгуулагчийн тоо 22,676 нэмэгдэж, орлого 164.5 тэрбум төгрөгөөр өссөн;
- Төсвийг үр ашигтай зарцуулах, батлагдсан төсөвт багтаан ажиллах зорилгоор зарим архаг өвчлөлөөс бусад тусламж, үйлчилгээг тодорхой түвшинд хязгаарлах, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг худалдан авах зэрэг арга хэмжээ авсан нь нөлөөлсөн байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 179.2 тэрбум төгрөг нь төрийн сангийн 4 харилцах дансанд, 38.1 тэрбум төгрөг нь арилжааны банкны 7 харилцах дансанд тус тус байршиж байна.

Арилжааны банкны үлдэгдэлд 38.1 тэрбум төгрөг байгаагаас 26.8 тэрбум төгрөг буюу 70.4 хувийг “Чингис хаан банк” ХХК-ийн үлдэгдэл эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 181/ШШ2020/02421 дүгээр шийдвэрээр “Чингис хаан банк” ХХК-ийн ЭМДС-ийн харилцах дансны 27.8 тэрбум төгрөгийн үлдэгдлийг тус банкаар төлүүлэхээр шийдвэрлэснээс 2024 онд 0.3 тэрбум төгрөг, тайлант онд 3.7 тэрбум төгрөгийг төлүүлсэн, Шүүхийн шийдвэрээс хойш 3.0 тэрбум төгрөгийн хүү нэмэгдэж, тайлант оны жилийн эцсийн байдлаар 26.8 тэрбум төгрөгийн харилцах дансны үлдэгдэл төлөгдөөгүй эрсдэлтэй хэвээр байна.

Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 5,868.0 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 370.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Улсын ТЕЗ-дын мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	46,706.9	43,216.3	(3,490.6)	0.7
Банканд байгаа бэлэн мөнгө	5,112,706.9	4,535,780.7	(576,926.2)	77.3
Замд яваа мөнгөн хөрөнгө	1,486.7	706.7	(780.0)	0.0
Хадгаламж	336,322.4	1,288,286.2	951,963.8	22.0
Дүн	5,497,223.0	5,867,989.9	370,766.9	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Улсын ТЕЗ-дын мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 4,535.8 тэрбум төгрөг буюу 77.3 хувь нь банкинд дахь мөнгөн хөрөнгө, 1,288.3 тэрбум төгрөг буюу 22.0 хувь нь хадгаламж, 0.7 хувь буюу 43.2 тэрбум төгрөг нь касст байгаа бэлэн мөнгө, 0.7 тэрбум төгрөг буюу 0.01 хувийг замд яваа мөнгөн хөрөнгө эзэлж байна.

Улсын ТЕЗ-дын мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 370.8 тэрбум төгрөгөөр өсөхөд төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө 651.4 тэрбум төгрөгөөр, төсөл, сангийн мөнгөн хөрөнгө 4.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Тухайлбал:

- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК 819.3 тэрбум төгрөгөөр, Монголын Хөрөнгийн бирж ХК 387.4 тэрбум төгрөгөөр, Хадгаламжийн даатгалын корпорац 103.2 тэрбум төгрөгөөр, “Төрийн банк” ХК 93.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн;
- Төсөл, сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл 19.6 тэрбум төгрөгөөр, “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл” 11.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн.

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн нийт 14.1 тэрбум төгрөг /ГБХНХС 3.2 тэрбум төгрөг, СС 1.7 тэрбум төгрөг, ЭМС 1.7 тэрбум төгрөг, БС 1.7 тэрбум төгрөг, ЗГХЭГ 1.7 тэрбум төгрөг, ЭХС 1.3 тэрбум төгрөг, ССАЖЗС 0.9 тэрбум төгрөг, БОУАӨС 0.5 тэрбум төгрөг, ЭЗХС 0.3 тэрбум төгрөг, ГХС 0.2 тэрбум төгрөг, ЭМДС 0.1 тэрбум төгрөг, МУЕС 0.1 тэрбум төгрөг, ЗТС 0.1 тэрбум төгрөг, ЭМДС 0.1 тэрбум төгрөг, НДҮЗД 0.1 тэрбум төгрөг, АҮЭБС 0.1 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.3 тэрбум төгрөг/;
- Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй “Чингис хаан банк” ХХК-д байршиж байгаа 187.6 тэрбум төгрөг, “Үндэсний хөрөнгө оруулалтын банк” ХХК-д байршиж байгаа 55.5 тэрбум төгрөг, нийт 243.1 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгөд эрсдэл үүссэн хэвээр байна;
- Улсын төсөвт төвлөрүүлбэл зохих түрээсийн орлого, төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлээгүй 0.2 тэрбум төгрөг /ССАЖЗС 0.07 тэрбум төгрөг, ГБХНХС 0.04 тэрбум төгрөг, БС 0.05 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.04 тэрбум төгрөг/.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,224.6 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 563.7 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Орон нутгийн ТЕЗ-дын мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	372.3	401.5	29.2	-
Банканд байгаа бэлэн мөнгө	798,495.8	629,525.3	(168,970.5)	28.3
Замд яваа мөнгөн хөрөнгө	318,244.8	27,221.5	(291,023.3)	1.2
Хадгаламж	1,671,216.9	1,567,454.0	(103,762.9)	70.5
Дүн	2,788,329.8	2,224,602.3	(563,727.5)	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Орон нутгийн ТЕЗ-дын 2,224.6 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 1,607.2 тэрбум төгрөг буюу 72.2 хувь төрийн сангийн, 558.2 тэрбум төгрөг буюу 25.1 хувийг орон нутгийн өмчит

болон орон нутгийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газрын, 51.6 тэрбум төгрөг буюу 2.3 хувийг төсөвт байгууллагын, 7.6 тэрбум төгрөг буюу 0.4 хувийг төсөл, сангийн мөнгөн хөрөнгө эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны баримтгүй болон бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар 9.7 тэрбум төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн /Нийслэл 4.3 тэрбум төгрөг, Өмнөговь 2.7 тэрбум төгрөг, Орхон 0.6 тэрбум төгрөг, Говь-Алтай 0.5 тэрбум төгрөг, Баян-Өлгий 0.4 тэрбум төгрөг, Сэлэнгэ 0.3 тэрбум төгрөг, Ховд 0.2 тэрбум төгрөг, Баянхонгор 0.1 тэрбум төгрөг, Булган 0.1 тэрбум төгрөг, Хөвсгөл 0.1 тэрбум төгрөг, Хэнтий 0.1 тэрбум төгрөг, Архангай 0.1 тэрбум төгрөг, бусад ТЭЗ 0.2 тэрбум төгрөг/;
- Санхүүгийн тайланд 0.9 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийг зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулж зөрүүтэй тайлагнасан /Нийслэл 0.4 тэрбум төгрөг, Ховд аймаг 0.2 тэрбум төгрөг, Төв аймаг 0.1 тэрбум төгрөг, бусад ТЭЗ 0.2 тэрбум төгрөг/;
- Ажилчдын цалин, урамшуулал нэмэгдлийг зөрүүтэй тооцож олгосон 3.4 тэрбум төгрөг /Орхон 0.5 тэрбум төгрөг, Архангай 0.4 тэрбум төгрөг, Өмнөговь 0.4 тэрбум төгрөг, Баянхонгор 0.4 тэрбум төгрөг, Говь-Алтай 0.3 тэрбум төгрөг, Баян-Өлгий 0.2 тэрбум төгрөг, Нийслэл 0.1 тэрбум төгрөг, Завхан 0.1 тэрбум төгрөг, Ховд 0.1 тэрбум төгрөг, бусад ТЭЗ 0.9 тэрбум төгрөг/.

5.2 БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 2,022.6 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 180.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 10. Богино хугацаат хөрөнгө оруулалт, байгууллагын төрлөөр

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төсөл/сан	495,704.9	964,461.0	468,756.1	47.7
Боловсролын зээлийн сан	58.2	19.6	(38.6)	-
Хуримтлалын сан	495,646.7	964,441.4	468,794.7	47.7
Төрийн болон орон нутгийн өмчит	1,346,602.2	1,058,165.6	(288,436.6)	52.3
Монголын хөрөнгийн бирж ХК	-	50,781.2	50,781.2	2.5
Монгол Улсын Их сургууль	-	1,300.2	1,300.2	0.1
Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент ҮЦК ХХК	2,450.0	1,869.0	(581.0)	0.1
Төрийн банк ХК	1,344,152.2	1,004,215.2	(339,937.0)	49.6
Нийт дүн	1,842,307.1	2,022,626.6	180,319.5	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдлийн 1,004.2 тэрбум төгрөг буюу 49.6 хувийг “Төрийн банк” ХК, 964.4 тэрбум төгрөг буюу 47.7 хувийг Хуримтлалын сан, 50.8 тэрбум төгрөг буюу 2.5 хувийг “Монголын хөрөнгийн бирж” ХК, 1.9 тэрбум төгрөг буюу 0.1 хувийг “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК” ХХК, 1.3 тэрбум төгрөг буюу 0.1 хувийг Монгол Улсын Их сургууль тус тус эзэлж байна.

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэлд эзлэх хувийг байгууллагын төрлөөр авч үзвэл 1,058.2 тэрбум төгрөг буюу 52.3 хувийг төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд, 964.5 тэрбум төгрөг буюу 47.7 хувийг төсөл, сангийн хөрөнгө эзэлж байна.

5.3 АВЛАГА

Авлага дансны үлдэгдэл 7,606.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 794.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 11. Авлага дансны ангилал, байгууллагын төрлөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагсадтай холбогдсон авлага	4,136.5	8,128.6	3,992.1	0.1
Төлбөртэй үйлчилгээний авлага	86,903.0	101,120.9	14,217.9	1.3
Татаас, санхүүжилтийн авлага	197,631.8	227,485.4	29,853.5	3.0
Зээлийн хүүгийн авлага	330,408.5	187,944.1	(142,464.4)	2.5
Дансны авлага /ТӨҮГ/	1,194,216.8	1,312,472.6	118,255.8	17.3
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	860,111.3	1,329,555.8	469,444.6	17.5
Бусад авлага	1,976,888.7	2,136,943.0	160,054.3	28.1
Байгууллагаас авах авлага	1,828,820.3	1,967,576.0	138,755.7	25.9
Хувь хүмүүсээс авах авлага	148,068.4	169,367.0	21,298.5	2.2
Зээлийн авлага	2,161,393.0	2,302,467.9	141,074.9	30.3
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	1,144,409.0	1,183,517.1	39,108.1	15.6
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	1,016,984.0	1,118,950.8	101,966.8	14.7
Дүн	6,811,689.6	7,606,118.3	794,428.7	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
ТӨҮГ болон ОНӨҮГ	3,101,731.7	3,460,011.6	358,279.9	45.5
Төрийн сан	1,435,236.9	1,666,000.6	230,763.7	21.9
Төсөвт байгууллага	728,947.9	691,806.1	(37,141.8)	9.1
Төсөл/Сан	1,545,773.1	1,788,300.0	242,526.9	23.5
Дүн	6,811,689.6	7,606,118.3	794,428.7	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны нийт үлдэгдлээс зээлийн авлага 2,302.5 тэрбум төгрөг буюу 30.3 хувийг, бусад авлага 2,136.9 тэрбум төгрөг буюу 28.1 хувийг, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн татвар, НДШ-ийн авлага 1,329.5 тэрбум төгрөг буюу 17.5 хувийг, дансны авлага 1,312.5 тэрбум төгрөг буюу 17.3 хувийг, татаас санхүүжилтийн авлага 227.5 тэрбум төгрөг буюу 3.0 хувийг, зээлийн хүүгийн авлага 187.9 тэрбум төгрөг буюу 2.5 хувийг, ажиллагсадтай холбоотой авлага болон төлбөртэй үйлчилгээний авлага 109.2 тэрбум төгрөг буюу 1.4 хувийг тус тус эзэлж байна.

Татвар, НДШ-ийн авлага 469.4 тэрбум төгрөгөөр, бусад авлага 160.0 тэрбум төгрөгөөр, зээлийн авлага 141.0 тэрбум төгрөгөөр, дансны авлага 118.3 тэрбум төгрөгөөр, татаас санхүүжилтийн авлага 29.8 тэрбум төгрөгөөр, төлбөртэй үйлчилгээний авлага 14.2 тэрбум төгрөгөөр, ажиллагсадтай холбоотой авлага 3.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Тайлант онд татвар, НДШ-ийн авлага 469.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ 175.5 тэрбум төгрөгөөр, “Монголын төмөр зам” ТӨХК 65.7 тэрбум төгрөгөөр, “МИАТ” ТӨХК 23.5 тэрбум төгрөгөөр, “Таван толгой түлш” ХХК 13.3 тэрбум төгрөг, нийт 264.5 тэрбум төгрөгийн татварыг урьдчилж төлсөн нь голлон нөлөөлжээ.

Төв төрийн сангийн авлага

Төв төрийн сангийн авлагын эцсийн үлдэгдэл 1,646.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 233.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 12. Төв төрийн сангийн авлага

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт + бууралт -	Дүнд эзлэх хувь
Зээлийн хүүгийн авлага	81,874.9	66,683.2	(15,191.7)	4.0
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	124,552.1	253,924.0	129,371.9	15.4
Бусад авлага	219,999.1	195,322.6	(24,676.5)	11.9
Зээлийн авлага	987,368.2	1,130,922.5	143,554.3	68.7
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	9,613.2	30,214.0	20,600.8	1.8
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	977,755.0	1,100,708.5	122,953.5	66.8
Дүн	1,413,794.3	1,646,852.3	233,058.0	100.0

Эх сурвалж: Төв төрийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан

Төв төрийн сангийн нийт 1,646.8 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдлээс 1,130.9 тэрбум төгрөг буюу 68.7 хувийг дотоод, гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага, 253.9 тэрбум төгрөг буюу 15.4 хувийг татвар, НДШ-ийн авлага, 195.3 тэрбум төгрөг буюу 11.9 хувийг бусад авлага, 66.7 тэрбум төгрөг буюу 4 хувийг зээлийн хүүгийн авлага эзэлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн татварын авлага 129.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь өмнөх оны үлдэгдлээс 74.5 тэрбум төгрөгийг барагдуулж, Монгол Улсын Засгийн газрын 2022-2025 онд баталсан тогтоолууд болон гуравласан гэрээний дагуу 240.1 тэрбум төгрөгийн гаалийн татварыг хойшлуулсантай холбоотой байна.

Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага

Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагын эцсийн үлдэгдэл 1,100.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 122.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 13. Төв төрийн сангийн гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн авлага

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	376,128.8	415,377.9	39,249.1	37.7
Төрийн өмчит хуулийн этгээдэд олгосон зээл	230,632.3	325,819.1	95,186.8	29.6
Хувийн хэвшлийн хуулийн этгээдэд олгосон зээл	370,993.9	359,511.5	(11,482.4)	32.7
Дүн	977,755.0	1,100,708.5	122,953.5	100.0

Эх сурвалж: Төв төрийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан

Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагын 415.3 тэрбум төгрөг буюу 37.7 хувийг Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон зээл, 325.8 тэрбум төгрөг буюу 29.6 хувийг төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдэд олгосон зээл, 359.5 тэрбум төгрөг буюу 32.7 хувийг хувийн хэвшлийн хуулийн этгээдэд олгосон зээл тус тус эзэлж байна.

Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн авлага 122.9 тэрбумаар өссөн нь тайлант онд 401.3 тэрбум төгрөгийн ашиглалт гарч, зээлийн үндсэн төлбөрт 285.3 тэрбум төгрөгийг төлсөн, 72.0 тэрбум төгрөгийн валютын ханшийн зөрүү үүссэнээс тус тус шалтгаалжээ.

Тайлант онд зээлийн үндсэн төлбөрт 285.3 тэрбум төгрөг, зээлийн хүүгийн төлбөрт 82.9 тэрбум төгрөг, нийт 368.2 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн гэрээний дагуу хэрэгжиж байгаа 19 төслийн тайлант онд гарсан ашиглалтын 401.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 24 дэд зээлдэгчид олгосон байна. Тайлант онд 1996-2021 онд гэрээ байгуулсан 270.7 тэрбум төгрөгийн гэрээний дүн бүхий 17 төсөл, хөтөлбөрийн авлага бүрэн төлөгдөж дууссан байна.

Аудитын илрүүлэлт:

- Дамжуулан зээлийн авлагаас шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болсон 126.4 тэрбум төгрөгийн авлага (27 аж ахуй нэгжид 1991-1994 онд гэрээ байгуулж олгосон) дансанд бүртгэлтэй байгаагаас шалтгаалж ханшийн зөрүүгээр 15.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 142.2 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. /СС 142.2 тэрбум төгрөг/;
- Тайлант онд эргэн төлөлт хангалтгүй 217.0 тэрбум төгрөг, тооцоо нийлэх боломжгүй 106.7 тэрбум төгрөг, нийт 323.7 тэрбум төгрөгийн дамжуулан зээлийн авлага байна. /СС 71.5 тэрбум төгрөг, 99.1 , 110.5 , 42.6 /.

Төсөвт байгууллагын авлага

Төсөвт байгууллагын авлагын үлдэгдэл 691.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 37.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 14. Төсөвт байгууллагын авлага

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Улсын төсөв	472,910.0	438,078.7	(34,831.3)	63.3
Орон нутаг	256,037.9	253,727.4	(2,310.5)	36.7
Дүн	728,947.9	691,806.1	(37,141.8)	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсөвт байгууллагын нийт авлагын 438.0 тэрбум төгрөг буюу 63.3 хувийг ТЕЗ-дын авлага, 253.7 тэрбум төгрөг буюу 36.7 хувийг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын авлага эзэлж байна.

Төсөвт байгууллагын авлага өмнөх оноос 37.1 тэрбум төгрөгөөр буюу 5.0 хувиар буурахад ХХААХҮС-ын авлага 13.8 тэрбум төгрөг, ЗТС-ын авлага 12.5 тэрбум төгрөг, СС-ын авлага 7.7 тэрбум төгрөг, орон нутгийн төсөвт байгууллагын авлага 2.2 тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Улсын ТЕЗ-дын нийт авлагын 160.3 тэрбум төгрөг буюу 36.6 хувийг ГБХНХС, 80.9 тэрбум төгрөг буюу 18.5 хувийг ХЗДХС, 45.1 тэрбум төгрөг буюу 10.3 хувийг ХХААХҮС, 151.7 тэрбум төгрөг буюу 34.6 хувийг бусад ТЕЗ-дын авлага эзэлж байна.

Орон нутгийн төсөвт байгууллагын авлагын 105.2 тэрбум төгрөг буюу 41.5 хувийг Нийслэл, 7.2 тэрбум төгрөг буюу 2.8 хувийг Дундговь, 13.7 тэрбум төгрөг буюу 5.4 хувийг Төв, бусад орон нутгийн ТЕЗ 127.5 тэрбум төгрөг буюу 50.2 хувийг тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Олон жилийн насжилттай, зээлийн хугацаа хэтэрсэн, авлага барагдуулах арга хэмжээ аваагүй, найдваргүй болох эрсдэлтэй авлагын үлдэгдэлтэй зэрэг нийт 55.0 тэрбум төгрөг /Нийслэл 43.4 тэрбум төгрөг, АҮЭБС 8.1 тэрбум төгрөг, ХХААХҮС 0.9 тэрбум төгрөг, БОУАӨС 0.3 тэрбум төгрөг, ЗТС 0.8 тэрбум төгрөг, ЭХС 0.1 тэрбум төгрөг, бусад төсвийн байгууллага 1.4 тэрбум төгрөг/;
- Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нийт 9.8 тэрбум төгрөг /ЭМС 6.2 тэрбум төгрөг, Нийслэл 2.3 тэрбум төгрөг, ГБХНХС 0.2 тэрбум төгрөг, ССАЖЗС 0.2 тэрбум төгрөг, ХХААХҮС 0.2 тэрбум төгрөг, Дундговь 0.1 тэрбум төгрөг, бусад төсвийн байгууллага 0.6 тэрбум төгрөг/;
- Авлага дансанд бүртгээгүй, авлагыг зөрүүтэй тайлагнасан зэрэг нийт 1.5 тэрбум төгрөг /ЭМС 0.2 тэрбум төгрөг, Ховд 0.1 тэрбум төгрөг, Нийслэл 0.04 тэрбум төгрөг, Сэлэнгэ 0.04 тэрбум төгрөг, бусад төсвийн байгууллага 1.1 тэрбум төгрөг/.

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлага

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлага 3,460.0 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 358.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 15. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлага

/сая төгрөгөөр/

Өмчийн хэлбэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд	2,878,948.0	3,238,979.6	360,031.6	93.6
Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд	222,783.7	221,032.0	(1,751.7)	6.4
Дүн	3,101,731.7	3,460,011.6	358,279.9	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 3,238.9 тэрбум төгрөг буюу 93.6 хувийг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, 221.0 тэрбум төгрөг буюу 6.4 хувийг орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлага эзэлж байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлага өмнөх оноос 360.0 тэрбум төгрөгөөр буюу 12.5 хувиар өссөн нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ 185.0 тэрбум төгрөгөөр, “Таван толгой төмөр зам” ХХК 77.9 тэрбум төгрөгөөр, “Эрчис ойл” ХХК 12.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлага өмнөх оноос 1.7 тэрбум төгрөгөөр буюу 0.7 хувиар буурсан нь “Улаанбаатар спорт менежмент” ОНӨААТҮГ 1.1 тэрбум төгрөг, “Дэд бүтцийн хөгжлийн алба” ОНӨААТҮГ 0.2 тэрбум төгрөг, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар 0.4 тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Төсвийг зохистой удирдаагүй, арга хэмжээ авч ажиллаагүй тайлант онд нийт 13.1 тэрбум төгрөгийн авлага үүсгэсэн /“Цемент шохой” ХК 12.3 тэрбум төгрөг, “Ховд” АЗЗА 0.7 тэрбум төгрөг, Төв аймгийн “Барилга захиалагч, орон сууцны корпорац” ОНӨҮГ 0.1 тэрбум төгрөг, бусад байгууллага 0.02 тэрбум төгрөг/;
- Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нийт 541.5 тэрбум төгрөг /“Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК 349.2 тэрбум төгрөг, “Таван толгой төмөр зам” ХК 83.9 тэрбум төгрөг, “Хөдөө аж ахуйн корпорац” ТӨХХК 44.0 тэрбум төгрөг, “Эрдэнэс алт ресурс” ХК 42.3 тэрбум төгрөг, “Монголын төмөр зам” ТӨХК 7.9 тэрбум төгрөг, “Амгалан дулааны станц” ТӨХК 3.6 тэрбум төгрөг, “Иргэний нисэхийн үндэсний төв” 3.2 тэрбум төгрөг, “Төрийн орон сууцны корпорац” ХК 1.4 тэрбум төгрөг, “Багануур” ХК 1.3 тэрбум төгрөг, “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ 0.7 тэрбум төгрөг, “Олон Улсын худалдаа ложистикийн төв” ХК 0.6 тэрбум төгрөг, “Дулааны дөрөвдүгээр станц” ТӨХК 0.5 тэрбум төгрөг, “Геологийн судалгаа шинжилгээний хүрээлэн” ТӨҮГ 0.4 тэрбум төгрөг, “Таван толгой түлш” ХХК 0.4 тэрбум төгрөг, ШУТИС 0.4 тэрбум төгрөг, “Монгол шуудан” ХК 0.4 тэрбум төгрөг, “Цемент шохой” ХК 0.3 тэрбум төгрөг, “Дулааны гуравдугаар станц” ТӨХК 0.2 тэрбум төгрөг, УАӨСХА-ы төв 0.1 тэрбум төгрөг, “Мэдээлэл технологийн үндэсний парк” ТӨҮГ 0.1 тэрбум төгрөг, “Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК 0.08 тэрбум төгрөг, бусад ТӨХК 0.5 тэрбум төгрөг/;
- Олон жилийн насжилттай, зээлийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ аваагүй, найдваргүй болох эрсдэлтэй зэрэг нийт 16.1 тэрбум төгрөг /“Хөдөө аж ахуй корпорац” ТӨХК 5.5 тэрбум төгрөг, “Эрчис ойл” ХХК 5.5 тэрбум төгрөг, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК 2.7 тэрбум төгрөг, ХААИС 0.8 тэрбум төгрөг, “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ 0.5 тэрбум төгрөг, “МЦХ” ХК 0.1 тэрбум төгрөг, Монгол улсын далайн захиргаа 0.2 тэрбум төгрөг, “Монгол шуудан” ХК 0.1 тэрбум төгрөг, “Таван толгой төмөр зам” ХХК 0.1 тэрбум төгрөг, Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац 0.2 тэрбум төгрөг, бусад байгууллага 0.4 тэрбум төгрөг/;
- Авлагын дансанд бүртгээгүй, зөрүүтэй тайлагнасан 1.5 тэрбум төгрөг /“УБЦТС” ТӨХК 0.8 тэрбум төгрөг, “Монголын хөрөнгийн бирж” ХК 0.1 тэрбум төгрөг, бусад байгууллага 0.6 тэрбум төгрөг/.

Төсөл, сангуудын авлага

Төсөл, сангийн авлагын үлдэгдэл 1,788.3 тэрбум төгрөг болж, 242.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 16. Төсөл, сангийн авлага

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт+ бууралт -	Дүнд ээлэх хувь
Нийгмийн даатгалын сан	726,713.8	868,268.9	141,555.1	48.6
Эрүүл мэндийн даатгалын сан	166,539.0	194,272.8	27,733.8	10.9
Сангийн сайд	5,734.8	17,838.3	12,103.5	1.0
Үндэсний баялгийн сан	-	43,983.7	43,983.7	2.5
Боловсролын сайд	269,454.3	301,639.3	32,185.0	16.9
Бусад	377,331.1	362,297.0	(15,034.1)	20.3
Дүн	1,545,773.0	1,788,300.0	242,527.0	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсөл, сангийн нийт авлагын Нийгмийн даатгалын сан 868.2 тэрбум төгрөг буюу 48.6 хувийг, Эрүүл мэндийн даатгалын сан 194.2 тэрбум төгрөг буюу 10.9 хувийг, Үндэсний баялгийн сан 43.9 тэрбум төгрөг буюу 2.5 хувийг, Сангийн сайд 17.8 тэрбум төгрөг буюу 2.5 хувийг, Боловсролын сайд 301.6 тэрбум төгрөг буюу 16.9 хувийг, бусад ТЕЗ-дын авлага 362.2 тэрбум төгрөг буюу 20.3 хувийг тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Олон жилийн насжилттай, зээлийн хугацаа хэтэрсэн, авлага барагдуулах арга хэмжээ аваагүй, найдваргүй болох эрсдэлтэй, шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлээгүй зэрэг нийт 40.6 тэрбум төгрөг /ХЭДС 34.3 тэрбум төгрөг, Булган аймгийн ХХС 1.4 тэрбум төгрөг, Төв аймгийн ХХС 1.5 тэрбум төгрөг, Завхан аймгийн ХЭДС 0.6 тэрбум төгрөг, Завхан аймгийн ХХС 0.4 тэрбум төгрөг, Ховд аймгийн ХХС 0.4 тэрбум төгрөг, ГАА-ийн ХХС 0.09 тэрбум төгрөг, Архангай аймгийн ХХС 0.06 тэрбум төгрөг, БЗС-ийн 0.04 тэрбум төгрөг, Баянхонгор аймгийн ХХС 0.08 тэрбум төгрөг, ЭЗХАБХТ 0.1 тэрбум төгрөг, бусад байгууллага 1.6 тэрбум төгрөг/;
- Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нийт 32.2 тэрбум төгрөг /ЖДҮХС 30.4 тэрбум төгрөг, Нийтийн тээврийг хөгжүүлэх сан 0.6 тэрбум төгрөг, ХБХХЕГ-ын ХЭДС 0.6 тэрбум төгрөг, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан 0.3 тэрбум төгрөг, бусад байгууллага 0.3 тэрбум төгрөг/.

Нийгмийн даатгалын сангийн авлага

Нийгмийн даатгалын сангийн нийт авлагын үлдэгдэл 868.3 тэрбум төгрөг болж, 141.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 17. Нийгмийн даатгалын сангийн авлага

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өсөлт (+), бууралт (-)	Дүнд ээлэх хувь
Татаас, санхүүжилтийн авлага	197,631.8	197,239.4	(392.4)	22.7
Зээлийн хүүгийн авлага	5,204.6	5,358.0	153.4	0.6
НДШ-ийн авлага /ТӨҮГ/	439,549.6	590,430.6	150,881.0	68.0
Бусад авлага	84,327.7	75,241.0	(9,086.7)	8.7
Байгууллагаас авах авлага	76,185.6	67,028.0	(9,157.6)	7.7
Хувь хүмүүсээс авах авлага	8,142.2	8,213.0	70.9	1.0
Дүн	726,713.8	868,268.9	141,555.1	100.0

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 590.4 тэрбум төгрөг буюу 68.0 хувийг 40,752 аж ахуйн нэгж, байгууллагаас авах НДШ-ийн авлага, 197.2 тэрбум төгрөг буюу 22.7 хувийг татаас санхүүжилтийн авлага, 5.4 тэрбум төгрөг буюу 0.6 хувийг зээлийн хүүгийн авлага, 75.2 тэрбум төгрөг буюу 8.7 хувийг бусад авлага тус тус эзэлж байна.

Авлага дансны үлдэгдэл өмнөх оноос 141.6 тэрбум төгрөгөөр өссөн нь аж, ахуйн нэгж, байгууллагаас авах НДШ-ийн авлага 150.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Тухайлбал:

- НДС-ийн нийт авлагын үлдэгдэл 868.3 тэрбум төгрөгөөс 590.4 тэрбум төгрөг нь 40,752 аж ахуйн нэгж, байгууллагаас авах авлага;
- УИХ-ын 2020 оны Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль болон Засгийн газрын 2020 оны 140 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ын хүрээнд ажил олгогч, даатгуулагчийн чөлөөлөгдсөн 197.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийн үлдэгдэл;
- НДС-ийн чөлөөт мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс өмнөх онд Засгийн газрын 3 жилийн хугацаатай үнэт цаасыг 300.0 тэрбум төгрөгөөр худалдан авснаас тайлант онд 5.4 тэрбум төгрөгийн хүүгийн авлага бүртгэсэн;
- “Капитал банк” ХХК дахь эрх хүлээн авагчаас авах авлагаас тайлант онд мөнгөн хөрөнгөөр 1.6 тэрбум төгрөг, орон сууц, авто зогсоолын зориулалттай 6.5 тэрбум төгрөгийн 11 үл хөдлөх хөрөнгө авч, нийт 8.1 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулсан.

Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 181/ШШ2024/00464 дүгээр шийдвэрээр “Чингис хаан банк” ХХК-д байршиж буй дансны үлдэгдэлд тооцсон хүүгийн авлагын 1.8 тэрбум төгрөг барагдаагүй байна.

“Капитал банк” ХХК дахь эрх хүлээн авагчаас авах өмнөх оны үлдэгдэл 65.7 тэрбум төгрөгөөс 8.1 тэрбум төгрөгийг барагдуулж, 57.6 тэрбум төгрөгийг барагдуулаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- “Капитал банк” ХХК дахь эрх хүлээн авагчаас 57.6 тэрбум төгрөгийн авах авлагын үлдэгдэлтэй;
- Олон жилийн насжилттай өмнөх оны үлдэгдэл 6.4 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах талаар хууль, хяналтын байгууллагад хандсан боловч хангалттай үр дүнд хүрээгүй;
- Олон жилийн насжилттай, авлага барагдуулах арга хэмжээ аваагүй, найдваргүй болох эрсдэлтэй, шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлээгүй, өмнөх оноос авлага нэмэгдсэн нийт 8.8 тэрбум төгрөг / Өмнөговь НДС 7.6 тэрбум төгрөг, БЗД НДС 0.4 тэрбум төгрөг, Говьсүмбэр НДС 0.3 тэрбум төгрөг, БГД НДС 0.5 тэрбум төгрөг/;
- Нэг жилээс дээш насжилттай нийт 0.6 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй /Архангай аймгийн НДС 0.01 тэрбум төгрөг, Дорнод аймгийн НДС нь 0.6 тэрбум төгрөг/;
- Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй /СБД НДС 0.8 тэрбум төгрөг/.

Эрүүл мэндийн даатгалын сангийн авлага

Авлага дансны үлдэгдэл 194.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 25.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 18. Эрүүл мэндийн даатгалын сангийн авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	Хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.3	-	(0.3)	-
Байгууллагаас авах авлага	168,798.7	194,272.8	25,474.1	100.0
Нийт авлагын дүн	168,799.0	194,272.8	25,473.8	100.0

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд ЭМДШ-ийн авлага 27.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, “Капитал банк” ХХК дахь банкны эрх хүлээн авагчаас 1.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, авлага дансны үлдэгдэл 25.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Авлагын дансанд “Капитал банк” ХХК дахь эрх хүлээн авагчаас авах 74.2 тэрбум төгрөг, “Үндэсний хөрөнгө оруулалтын банк” ХХК-аас авах 2.1 тэрбум төгрөг, “Хаппи веритас” ХХК-ийн Интерферон альфа эмнэлгээс авах авлага 0.9 тэрбум төгрөгийн шүүхийн шийдвэртэй он дамжсан үлдэгдэл байна.

“Капитал банк” ХХК дахь банкны эрх хүлээн авагчийн 2019 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 1679 дүгээр албан бичгээр Эрүүл мэндийн даатгалын санд төлөх өглөгийн дүнг 136.1 тэрбум төгрөгөөр баталгаажуулснаас тайлант онд мөнгөн хөрөнгөөр 15.2 тэрбум төгрөг, үл хөдлөх

хөрөнгөөр 46.7 тэрбум төгрөг, нийт 61.9 тэрбум төгрөгийг барагдуулж, 74.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 181/ШШ2022/01219 дүгээр шийдвэрээр “Үндэсний хөрөнгө оруулалтын банк” ХХК-аас авах 2.1 тэрбум төгрөгийн хүүгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Олон жилийн насжилттай, авлагын барагдуулалт удаашралтай нийт 77.2 тэрбум төгрөг;
- Тайлант онд хувийн хэвшлийн нэр бүхий 17 эмнэлэгт эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэхэмжлэлээс илүү нийт 0.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг урьдчилж олгосон.

5.4 УРЬДЧИЛГАА

Урьдчилгаа дансны үлдэгдэл 3,902.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 1,989.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 19. Урьдчилгаа данс байгууллагын төрлөөр

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ТӨҮГ болон ОНӨҮГ	4,806,175.1	2,655,266.8	(2,150,908.3)	68.0
Төрийн сан	-	-	-	-
Төсөвт байгууллага	436,463.2	666,385.4	229,922.3	17.1
Төсөл/сан	648,921.6	580,790.1	(68,131.5)	14.9
Дүн	5,891,559.9	3,902,442.3	(1,989,117.5)	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны нийт үлдэгдлийн 2,655.3 тэрбум төгрөг буюу 68.0 хувийг төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн, 666.3 тэрбум төгрөг буюу 17.1 хувийг төсөвт байгууллага, 580.8 тэрбум төгрөг буюу 14.9 хувийг төсөл/сангуудын урьдчилгааны дүн тус тус эзэлж байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл өмнөх оноос 1,989.1 тэрбум төгрөгөөр буурахад “Таван толгой төмөр зам” ХК 1,338.8 тэрбум төгрөг, “Эрдэнэс Таван толгой” ХК 775.0 тэрбум төгрөг, “Тавантолгой” ХК 40.3 тэрбум төгрөг, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК 19.9 тэрбум төгрөг, “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын 7.6 тэрбум төгрөг, “Эрдэнэс Оюутолгой” ХК 5.7 тэрбум төгрөг, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК 5.7 тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Төсөвт байгууллагын урьдчилгаа 229.9 тэрбум төгрөгөөр өссөн нь Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн гүйцэтгэгч Пауэр Чайна-Пауэр Чайна Чэнгдү түншлэл компанид олгосон 30.0 хувийн урьдчилгаа төлбөр 79.9 сая ам.доллараас Монголын талын хариуцах 5.0 хувийн санхүүжилт 13.6 тэрбум төгрөг, БНХАУ-ын Экспорт-Импорт банкнаас тус компанид шилжүүлсэн 272.4 тэрбум төгрөгийн төлбөрийг урьдчилгаа дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Төсөл, сангийн урьдчилгаа дансны үлдэгдэл 580.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 68.1 тэрбум төгрөгөөр буурахад Улаанбаатар хотын хатуу хог хаягдлыг боловсруулах байгууламжийг шинэчлэх төсөл 45.2 тэрбум төгрөг, Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төсөл 44.6 тэрбум төгрөг, Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуйн төсөл 43.6 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийг ангилал шилжүүлэн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Он дамжсан урьдчилгааг барагдуулах арга хэмжээ аваагүй, гэрээний биелэлтэд тавих дотоод хяналт хангалтгүй зэрэг нийт 41.5 тэрбум төгрөг /Үндэсний геологийн алба 41.2 тэрбум төгрөг, Чингис хааны өв соёлын хүрээлэн 0.3 тэрбум төгрөг/;
- Урьдчилгаа төлбөрийг тайлант онд ногдох зардлаар хүлээн зөвшөөрөөгүй, дансны бичилт буруу бүртгэсэн 0.2 тэрбум төгрөг /Үндэсний статистикийн хороо 0.1 тэрбум төгрөг, ТАЗ 0.02 тэрбум төгрөг, Ёс зүйн хороо 0.01 тэрбум төгрөг, БГД 0.01 тэрбум төгрөг, НД-ийн ЖДҮДТ 0.02 тэрбум төгрөг, СБД-ийн ХГБХХЕГ 0.03, бусад 0.01 тэрбум төгрөг/.

5.5 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материал дансны үлдэгдэл 4,675.0 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 412.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 20. Бараа материал данс байгууллагын төрлөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Түүхий эд материал	1,321,132.7	1,444,765.5	123,632.8	30.9
Дуусаагүй үйлдвэрлэл	198,061.6	172,855.5	(25,206.1)	3.7
Бэлэн бүтээгдэхүүн	1,366,921.1	1,509,784.2	142,863.1	32.3
Хангамжийн материал	1,325,406.8	1,494,919.6	169,512.8	32.0
Биологийн хөрөнгө	5,235.8	14,693.5	9,457.7	0.3
Мал амьтад	45,680.4	37,987.9	(7,692.5)	0.8
Дүн	4,262,438.4	4,675,006.2	412,567.8	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,582,429.2	2,807,789.0	225,359.8	60.0
Төсөвт байгууллага	1,575,267.9	1,784,097.5	208,829.6	38.2
Төсөл/ сан	104,741.3	83,119.7	(21,621.6)	1.8
Дүн	4,262,438.4	4,675,006.2	412,567.8	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны 1,509.8 тэрбум төгрөг буюу 32.3 хувийг бэлэн бүтээгдэхүүн, 1,494.9 тэрбум төгрөг буюу 32.0 хувийг хангамжийн материал, 1,444.8 тэрбум төгрөгийг буюу 30.9 хувийг түүхий эд материал, 172.8 тэрбум төгрөг буюу 3.7 хувийг дуусаагүй үйлдвэрлэл, 38.0 тэрбум төгрөг буюу 0.8 хувийг мал амьтад, 14.7 тэрбум төгрөг буюу 0.3 хувийг биологийн хөрөнгө тус тус эзэлж байна.

Бараа материал дансны үлдэгдэл 412.6 тэрбум төгрөгөөр өсөхөд бэлэн бүтээгдэхүүн 142.9 тэрбум төгрөг, түүхий эд материал 123.6 тэрбум төгрөг, хангамжийн материал 169.5 тэрбум төгрөг, биологийн хөрөнгө 9.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Бараа материал дансны 2,807.8 тэрбум төгрөг буюу 60.0 хувийг төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд, 1,784.1 тэрбум төгрөг буюу 38.2 хувийг төсөвт байгууллага, 83.1 тэрбум төгрөг буюу 1.8 хувийг төсөл, сангийн хөрөнгө тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй нийт 4.0 тэрбум төгрөг /БС 2.6 тэрбум төгрөг, Нийслэл 1.1 тэрбум төгрөг, бусад ТЭЗ 0.3 тэрбум төгрөг/;
- Шууд зардлаар бүртгэсэн нийт 2.6 тэрбум төгрөг /ЭМС 0.9 тэрбум төгрөг, ЭХС 0.3 тэрбум төгрөг, ССАЖЗС 0.3 тэрбум төгрөг, Нийслэл 0.9 тэрбум төгрөг, бусад ТЭЗ 0.2 тэрбум төгрөг/;
- Бараа материалын дансны ангилал буруу бүртгэсэн нийт 2.6 тэрбум төгрөг /МУШСОБХАЭ 1.1 тэрбум төгрөг, БС 0.5 тэрбум төгрөг, бусад ТЭЗ 1.0 тэрбум төгрөг/;
- Их хэмжээний бараа материал нөөцөлсөн, ашиглагдахгүй, өндөр насжилттай болон хугацаа дууссан нийт 19.3 тэрбум төгрөгийн бараа материал бүртгэлтэй /ХББОСС 10.1 тэрбум төгрөг, ЗГХЭГ 2.8 тэрбум төгрөг, ЭХС 2.5 тэрбум төгрөг, ХХААХҮС 1.4 тэрбум төгрөг, ЭМС 1.0 тэрбум төгрөг, бусад ТЭЗ 1.5 тэрбум төгрөг/;
- Бараа материалын тооллого хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй нийт 4.7 тэрбум төгрөг /ЭХС 1.7 тэрбум төгрөг, Нийслэл 1.6 тэрбум төгрөг, бусад ТЭЗ 1.4 тэрбум төгрөг/;
- Бараа материалын дансанд бүртгэлтэй нийт 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгө биетээр оршин байхгүй /ЭМС 0.7 тэрбум төгрөг, бусад ТЭЗ 0.3 тэрбум төгрөг/.

Нийгмийн даатгалын сангийн бараа материал

Бараа материал дансны үлдэгдэл 27.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 13.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 21. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Бэлэн бүтээгдэхүүн	13,533.0	27,366.5	13,833.6	100.0
Дүн	13,533.0	27,366.5	13,833.6	100.0

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны 27.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлд “Капитал банк” ХХК дахь эрх хүлээн авагчаас авах авлагад тооцсон 27 ширхэг нийт 19.9 тэрбум төгрөгийн үйлдвэр, үйлчилгээ, оффис, орон сууцны зориулалттай хөрөнгө, “Чингис хаан банк” ХХК-аас 2024, 2025 онд шилжүүлэн авсан 11 ширхэг 7.5 тэрбум төгрөгийн хөрөнгө тус тус бүртгэлтэй байна.

Тайлант онд дээрх хөрөнгийн ашиглалтын (цахилгаан, дулаан, үл хөдлөх хөрөнгийн зуучлалын гэх мэт) зардалд нийт 0.08 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 13.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь “Капитал банк” ХХК дахь эрх хүлээн авагчаас 6.5 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгө, “Чингис хаан банк” ХХК-аас 7.5 тэрбум төгрөгийн хөрөнгүүдийг авлагад тооцуулан шилжүүлэн авсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- “Капитал банк” ХХК дахь эрх хүлээн авагч болон “Чингис хаан банк” ХХК-аас 2021-2025 онд авлагад тооцуулан хүлээн авсан хөрөнгөөс өмнөх онд 2.6 тэрбум төгрөгийн хөрөнгө, тайлант онд 0.2 тэрбум төгрөгийн орон сууцны зориулалттай хөрөнгийг борлуулж, өмнөх оноос 92.3 хувиар буурсан нь 27.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг мөнгөн хөрөнгө болгох ажил удаашралтай, ашиглалтын зардал нэмэгдэх эрсдэлтэй байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн бараа материал

Бараа материал дансны үлдэгдэл 34.2 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 1.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.

“Капитал банк” ХХК дахь эрх хүлээн авагчаас хүлээж авсан 35.5 тэрбум төгрөгийн хөрөнгөөс 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг борлуулж, 33.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. ЭМДЕГ-ын даргын 2025 оны А/133 дугаар тушаалаар тус хөрөнгийн үлдэгдлийг худалдахаар нээлттэй дуудлага худалдаа зохион байгуулсан ч оролцогч ороогүй байна.

Аудитын илрүүлэлт:

- “Капитал банк” ХХК дахь эрх хүлээн авагчаас авлагад тооцуулан хүлээн авсан 33.9 тэрбум төгрөгийн хөрөнгийг мөнгөн хөрөнгө болгох ажил удаашралтай үлдэгдэлтэй байна.

5.6 НӨӨЦИЙН БАРАА

Нөөцийн бараа дансны үлдэгдэл 244.2 тэрбум төгрөг болж, 18.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 22. Нөөцийн бараа данс, байгууллагын төрлөөр

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Барааны нөөц	86,693.9	88,327.3	1,633.4	36.2
Үрийн нөөц	15,974.5	22,620.6	6,646.1	9.3
Тэжээлийн нөөц	18,110.6	23,059.2	4,948.6	9.4
Шатахууны нөөц	46,594.8	44,919.9	(1,674.9)	18.4
Буудайн нөөц	73,752.1	44,556.2	(29,195.9)	18.2
Бусад нөөц	21,083.6	20,723.0	(360.6)	8.5
Дүн	262,209.5	244,206.2	(18,003.3)	100.0
Үүнээс, байгууллагын төрлөөр				
ТӨҮГ болон ОНӨҮГ	121,690.9	92,019.1	(29,671.8)	37.7
Төсөвт байгууллага	140,269.3	151,876.2	11,606.9	62.2
Төсөл/сан	249.3	310.9	61.6	0.1
Дүн	262,209.5	244,206.2	(18,003.3)	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нөөцийн барааны үлдэгдэл өмнөх оноос 18.0 тэрбум төгрөгөөр буурсан нь “Хөдөө аж ахуйн корпорац” ТӨХХК-ийн буудайн нөөцийн огцом бууралт нөлөөлсөн бөгөөд энэ нь 2025 оны намрын ургац багасаж, улаан буудайн борлуулалт нэмэгдсэнтэй холбоотой байна.

5.7 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 17,894.5 тэрбум болж, өмнөх оноос 2,137.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 23. Бусад эргэлтийн хөрөнгө данс байгууллагын төрлөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,060,342.9	2,525,220.2	464,877.4	14.1
Төсөвт байгууллага	9,358,125.6	10,965,816.7	1,574,429.3	61.3
Төрийн сан	10,354.1	12,129.3	1,775.2	0.1
Төсөл/сан	4,328,101.5	4,391,364.4	96,524.6	24.5
Дүн	15,756,924.1	17,894,530.6	2,137,606.5	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 13.6 хувиар өсөхөд дараах өөрчлөлтүүд голлон нөлөөлжээ. Тухайлбал:

- Төсөвт байгууллагын бусад эргэлтийн хөрөнгө 1,574.4 тэрбум төгрөгөөр, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгө 464.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь дуусаагүй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг Засгийн Газрын 2023 оны 278 дугаар Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын дагуу бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэсэн;
- Төсөл, сангийн бусад эргэлтийн хөрөнгө 96.5 тэрбум төгрөгөөр өссөн нь гадаадын зээл, тусламжийн хүрээнд хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн барилга, дэд бүтэц, зөвлөх үйлчилгээний зардлыг бүртгэсэн.

Аудитын илрүүлэлт:

- БС: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 72.2 тэрбум төгрөгийн 37 төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй, удаашралтай байгаа өмнөх оны зөрчил давтагдан гарсан;
- ЗТС: Бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, 2020-2023 онд гүйцэтгэсэн 9 ажлын 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгийг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй, дуусаагүй үйлдвэрлэл дансанд 2017-2022 онд гүйцэтгэсэн 48 ажлын 115.6 тэрбум төгрөгийн замын ажлыг ашиглагч байгууллагад шилжүүлээгүй.

5.8 УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 13,456.2 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 164.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 24. Урт хугацаат хөрөнгө оруулалт, байгууллагын төрлөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Урт хугацаат хадгаламж	57,968.0	62,618.4	4,650.4	0.5
Үнэт цаас	2,659,976.4	2,342,338.1	(317,638.3)	17.4
Урт хугацаат зээл	10,574,052.2	11,051,272.9	477,220.7	82.1
Дотоод эх үүсвэрээр олгосон зээлийн авлага зээлийн авлага	5,928,851.2	5,749,731.8	(179,119.4)	
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	2,112.3	15,368.2	13,255.9	
Урт хугацаат хөрөнгө оруулалт	4,643,088.7	5,286,173.0	643,084.3	
Дүн	13,291,996.6	13,456,229.4	164,232.8	100.0

Өмнөх хэсэгт хувиартайгаар үзүүлж байна.

<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
ТӨҮГ болон ОНӨҮГ	10,813,811.4	10,754,054.5	(59,756.9)	79.9
Төрийн сан	2,419,857.9	2,301,417.5	(118,440.4)	17.1
Төсөвт байгууллага	58,327.3	67,023.9	8,696.6	0.5
Төсөл/Сан	-	333,733.5	333,733.5	2.5
Дүн	13,291,996.6	13,456,229.4	164,232.8	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат хөрөнгө оруулалтын дансны үлдэгдлийн 11,051.3 тэрбум төгрөг буюу 82.1 хувийг урт хугацаат зээл, 2,342.3 тэрбум төгрөг буюу 17.4 хувийг үнэт цаас, 62.6 тэрбум төгрөг буюу 0.5 хувийг урт хугацаат хадгаламж тус тус эзэлж байна.

Урт хугацаат хадгаламжийн дансны 62.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлд “Үндэсний давхар даатгал” ХК-ийн арилжааны банкнуудад байршуулсан хадгаламж эзэлж байна. Үүнд: “Төрийн банк” ХК-д 19.7 тэрбум төгрөг буюу 31.5 хувь, “Голомт банк” ХК-д 19.0 тэрбум төгрөг буюу 30.3 хувь, “Худалдаа хөгжлийн банк” ХК-д 10.8 тэрбум төгрөг буюу 17.2 хувь, “ХААН банк” ХК-д 8.4 тэрбум төгрөг буюу 13.5 хувийг, “ХАС банк” ХК-д 3.2 тэрбум төгрөг буюу 5.2 хувь, “Богд банк” ХК-д 0.6 тэрбум төгрөг буюу 1.0 хувь, “М банк” ХК-д 0.6 тэрбум төгрөг буюу 0.9 хувь, арилжааны банкны хадгаламжид хуримтлагдсан хүү 0.3 тэрбум төгрөг буюу 0.4 хувь тус тус бүртгэлтэй байна.

Урт хугацаат үнэт цаасны 2,342.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлд Төв төрийн сангийн үнэт цаас 55.2 хувь, “Төрийн банк” ХК-ийн үнэт цаас 20.6 хувь, Нийгмийн даатгалын сангийн үнэт цаас 12.8 хувь, “Монгол улсын хөгжлийн банк” ХХК-ийн үнэт цаас 11.4 хувийг тус тус эзэлж байна.

Урт хугацаат үнэт цаасны үлдэгдэл 317.6 тэрбум төгрөгөөр буурахад Засгийн газрын “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 34.0 хувийн хувьцааг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д шилжүүлэх тухай” 2025 оны 65 дугаар тогтоолоор нийт 693.8 тэрбум төгрөгийн хувьцааг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн гаргасан 750.0 тэрбум төгрөгийн бондоос суутган тооцож “Эрдэнэс Тавантолгой” ХК-д шилжүүлсэн нь голлон нөлөөлжээ.

5.9 ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл цэвэр дүнгээр 67,746.0 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 8,172.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 25. Үндсэн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Газар	46,095.3	46,095.3	-	0.1
Биет хөрөнгө	34,670,430.8	42,465,628.9	7,795,198.1	62.7
Биет бус хөрөнгө	19,600,156.1	21,186,442.3	1,586,286.2	31.3
Бусад хөрөнгө	5,256,466.2	4,047,859.3	(1,208,606.9)	6.0
Дүн	59,573,148.4	67,746,025.8	8,172,877.4	100.0
<i>Үүнээс байгууллагын төрлөөр</i>				
ТӨҮГ болон ОНӨҮГ	38,940,047.8	44,001,638.0	5,061,590.2	65.0
Төсөвт байгууллага	20,383,023.1	23,225,328.3	2,842,305.2	34.3
Төсөл/сан	250,077.5	519,059.5	268,982.0	0.7
Дүн	59,573,148.4	67,746,025.8	8,172,877.4	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийн 42,465.6 тэрбум төгрөг буюу 62.7 хувийг биет хөрөнгө, 21,186.4 тэрбум төгрөг буюу 31.3 хувийг биет бус хөрөнгө, 4,047.9 тэрбум төгрөг буюу 6.0 хувийг бусад хөрөнгө, 46.1 тэрбум төгрөг буюу 0.1 хувийг газар тус тус эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,172.9 тэрбум төгрөгөөр өссөн нь барилга байгууламж, орон сууц 5,296.6 тэрбум төгрөг, машин тоног төхөөрөмж 1,600.8 тэрбум төгрөг, бусад биет бус хөрөнгө 1,559.1 тэрбум төгрөг, авто тээврийн хэрэгсэл 0.9 тэрбум төгрөг, бусад үндсэн хөрөнгө 0.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Дуусаагүй барилга, байгууламж дансны үлдэгдлийн улсын ТЕЗ 4,746.4 тэрбум төгрөг буюу 96.1 хувийг, орон нутгийн ТЕЗ 191.5 тэрбум төгрөг буюу 3.9 хувийг тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, бүрэн хамруулаагүй, тооллогын дүн нь үлдэгдлийн дүнгээс зөрүүтэй, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, шилжилт хөдөлгөөнд тавих хяналт хангалтгүй, хөрөнгө биетээр оршин байхгүй зэрэг нийт 188.8 тэрбум төгрөг /ЭЗХС 144.9 тэрбум төгрөг, ГБХНХС 14.8 тэрбум төгрөг, БС 11.1 тэрбум төгрөг, ХЗДХС 8.0 тэрбум төгрөг, ХББОСС 5.3 тэрбум төгрөг, ЭМС 2.8 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 1.9 тэрбум төгрөг/;
- Эрх бүхий дээд шатны байгууллагын шийдвэргүйгээр хөрөнгө бэлтгэсэн, шилжүүлсэн, акталж данс бүртгэлээс хасалт хийсэн нийт 29.3 тэрбум төгрөг /ЗГХЭГ 19.2 тэрбум төгрөг, ЗТС 5.0 тэрбум төгрөг, ССАЖЗС 1.7 тэрбум төгрөг, ГХС 1.3 тэрбум төгрөг, ЭМС 1.3 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.8 тэрбум төгрөг/;
- Хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, ангилал зөрүүтэй тайлагнасан, элэгдлийн зардлыг зөрүүтэй тооцоолсон зэрэг нийт 542.6 тэрбум төгрөг /ЭХС 433.1 тэрбум төгрөг, ЗГХЭГ 81.4 тэрбум төгрөг, ХББОСС 15.0 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 13.1 тэрбум төгрөг/;
- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглаж байгаа хөрөнгийн цаашид ашиглах хугацаа болон үнийг шинэчлэн тогтоогоогүй нийт 237.5 тэрбум төгрөг /ЗГХЭГ 146.6 тэрбум төгрөг, МУШС/ОБ хариуцсан/ 33.3 тэрбум төгрөг, ЗТС 13.8 тэрбум төгрөг, ХББОСС 13.3 тэрбум төгрөг, АҮЭБС 10.4 тэрбум төгрөг, ГБХНХС 5.2 тэрбум төгрөг, ЭХС 4.7 тэрбум төгрөг, СС 4.1 тэрбум төгрөг, БС 3.3 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 2.8 тэрбум төгрөг/;
- Газар эзэмших эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгаагүй, кадастрын зураггүй, эзэмших эрхийг баталгаажуулаагүй, кадастрын зургаас зөрүүтэй бүртгэсэн зэрэг нийт 11.9 тэрбум төгрөг /БС 6.9 тэрбум төгрөг, ЗТС 4.8 тэрбум төгрөг, ХЗДХС 0.2 тэрбум төгрөг/;
- Программ хангамжийн бүртгэл, тайлагналтай холбоотой 47 төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 4285 байгууллагын мэдээлэлд судалгаа хийж нэгтгэсэн. Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд программ хангамжийн хэрэглээ өргөжин, түүнд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалт, хөгжүүлэлтийн зардал нэмэгдэж байгаа хэдий ч хөрөнгийн бүртгэл, тайлагналын үнэн зөв байдал хангалтгүй, өссөн дүнгээр 88.0 тэрбум төгрөгийн 8,175 (давхардсан тоогоор) программ хангамж /лиценз/-ыг санхүүгийн тайланд 21.3 тэрбум төгрөгөөр бууруулж, 66.7 тэрбум төгрөгөөр бүртгэсэн байна. Тайлант онд программын хөгжүүлэлт, лиценз сунгах үйлчилгээний зардалд 10.3 тэрбум төгрөг зарцуулснаас урсгал зардлын төсвөөс 3.5 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зардлын төсвөөс 6.8 тэрбум төгрөгийг тус тус санхүүжүүлсэн байна.

5.10 ӨР ТӨЛБӨР

Нийт өр төлбөрийн үлдэгдэл 61,094.2 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 3,370.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 26. Нийт өр, төлбөр дансны ангилал, байгууллагын төрлөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өссөн (+), Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	13,317,636.2	14,414,516.5	1,096,880.3	23.6
Богино хугацаат үнэт цаас	10,044.5	138,956.8	128,912.3	0.9
Богино хугацаат зээлийн өглөг	3,653,406.2	3,211,038.8	(442,367.4)	22.3
Өглөг	6,639,711.0	7,540,650.6	900,939.6	52.3
Урьдчилж орсон орлого	3,014,474.5	3,523,870.3	509,395.8	24.5
Урт хугацаат өр төлбөр дүн	44,406,365.5	46,679,699.4	2,273,333.9	76.4
Урт хугацаат үнэт цаас	15,560,012.0	15,763,011.5	202,999.5	33.8
Урт хугацаат зээл	28,846,353.5	30,916,687.9	2,070,334.4	66.2
Нийт өр төлбөрийн дүн	57,724,001.7	61,094,215.9	3,370,214.2	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
ТӨҮГ болон ОНӨҮГ	22,074,741.4	23,162,230.8	1,087,489.4	37.9
Төрийн сан	33,784,924.3	36,124,432.8	2,339,508.5	59.1
Төсөвт байгууллага	1,322,466.4	1,368,831.9	46,365.5	2.3
Төсөл/сан	541,869.6	438,720.4	(103,149.2)	0.7
Нийт өр төлбөрийн дүн	57,724,001.7	61,094,215.9	3,370,214.2	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн 36,124.4 тэрбум төгрөг буюу 59.1 хувийг төрийн сангийн, 23,162.2 тэрбум төгрөг буюу 37.9 хувийг төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн, 1,368.8 тэрбум төгрөг буюу 2.3 хувийг төсөвт байгууллагын, 438.7 тэрбум төгрөг буюу 0.7 хувийг төсөл, сангийн санхүүжилтийн үлдэгдэл тус тус эзэлж байна.

Засгийн газар өрийн удирдлагын хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлжээ. Тухайлбал,

- Монгол Улсын зээлжих зэрэглэлийг Эс энд Пи агентлагаас В+, эерэг байсныг ВВ-, тогтвортой түвшинд, Мүүдиз агентлагаас В2 тогтвортой түвшинд байсныг В1, тогтвортой түвшинд, Фитч агентлагаас В+, тогтвортой түвшинд хэвээр хадгалсан байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын зээлийн эрсдэлийн ангиллыг шинэчлэн тогтоох уулзалтаар Монгол Улсын зээлийн эрсдэлийн үнэлгээг нэг шат ахиулжээ.
- Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн зорилтын 4⁵-т заасны дагуу 2025 онд 148.7 тэрбум төгрөгийн үнэт цаасыг Монголын хөрөнгийн бирж ХК-аар дамжуулан арилжаалсан.
- Тайлант онд Сенчири-4 6.625 хувийн хүүтэй 500.0 сая ам.долларын буюу 1,731.5 тэрбум төгрөгийн бондыг 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр олон улсын зах зээлд арилжаалж, Номад бондоос 391.7 сая ам.доллар буюу 1,356.6 тэрбум төгрөг, Сенчири-2 бондоос 108.3 сая ам.доллар буюу 374.9 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний үнэт цаасыг дахин санхүүжүүлсэн байна.

Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 2024 онд 33,399.9 тэрбум төгрөг болж, ДНБ-ий 41.8 хувьтай, 2025 онд 35,407.6 тэрбум төгрөг болж, ДНБ-ий 39.4 хувьтай тэнцэж байна.

Засгийн газрын өрийн үлдэгдэлд гадаад өр 33,868.6 тэрбум төгрөг буюу 95.7 хувийг, дотоод өр 1,373.3 тэрбум төгрөг буюу 3.9 хувийг, Засгийн газрын өрийн баталгаа 165.7 тэрбум төгрөг буюу 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Төв төрийн сангийн өр төлбөр

Төв төрийн сангийн нийт өр төлбөрийн үлдэгдэл 33,657.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 2,382.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 27. Төв төрийн сангийн нийт өр, төлбөр дансны ангилал, /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+), Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	428,631.4	575,408.7	146,777.3	1.7
Богино хугацаат үнэт цаас	-	138,956.7	138,956.7	24.2
Өглөг	387,577.2	403,528.7	15,951.5	70.1
Урьдчилж орсон орлого	41,054.2	32,923.3	(8,130.9)	5.7
Урт хугацаат өр төлбөр дүн	30,846,150.4	33,081,993.5	2,235,843.1	98.3
Урт хугацаат үнэт цаас	9,265,014.7	9,922,588.2	657,573.5	30.0
Урт хугацаат зээл	21,581,135.7	23,159,405.3	1,578,269.6	70.0
Дүн	31,274,781.8	33,657,402.2	2,382,620.4	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төв төрийн сангийн нийт өр төлбөрийн 33,082.0 тэрбум төгрөг буюу 98.3 хувийг урт хугацаат өр төлбөр, 575.4 тэрбум төгрөг буюу 1.7 хувийг богино хугацаат өр төлбөр байна.

Төв төрийн сангийн үнэт цаас, зээл 5,227.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 3,158.4 тэрбум төгрөгийн төлбөр төлснөөр буурсан байна.

⁵ Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна

Хүснэгт 28. Гадаад, дотоод үнэт цаас, гадаад зээлийн өглөг				/сая төгрөгөөр/	
Үзүүлэлт	Гадаад үнэт цаас	Гадаад зээл	Дотоод үнэт цаас	Дүн	
Нэмэгдсэн дүн	2,069.7	2,859.5	298.7	5,227.9	
Бонд	1,731.5	-	298.7	2,030.2	
Зээлийн ашиглалт	-	1,541.2	-	1,541.2	
Ханшийн алдагдал	338.2	1,318.4	-	1,656.6	
Хасагдсан дүн	1,731.5	1,411.9	15.0	3,158.4	
Үндсэн төлбөр	1,731.5	1,411.9	15.0	3,158.4	
Хүүгийн төлбөр	625.3	589.1	35.5	1,250.0	

Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гадаад үнэт цаас: Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 8,964.7 тэрбум төгрөг болж өссөн бөгөөд Засгийн газрын нийт өрийн багцын 25.3 хувийг эзэлж байна.

Тайлант онд Номад бондын үндсэн төлбөрт 1,356.6 тэрбум төгрөг, Сенчири-2 бондын үндсэн төлбөрт 374.9 тэрбум төгрөг, нийт 1,731.5 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрийг төлж, Сенчири-4 бондыг олон улсын зах зээлд арилжаалсан.

Гадаад зээл: Олон улсын банк, санхүүгийн байгууллага болон түншлэгч орнуудын нийт 19 зээлдүүлэгчээс 317 төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор авсан зээлийн 22,927.9 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 148.0 тэрбум төгрөгийн хуримтлагдсан хүүгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл ашиглалт 1,541.2 тэрбум төгрөг, хуримтлагдсан хүү 148.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, үндсэн төлбөрийн төлөлт 1,411.9 тэрбум төгрөг, ханшийн тэгшитгэлийн зөрүү 1,318.4 тэрбум төгрөг, нийт үлдэгдэл 23,075.9 тэрбум төгрөг болж, Засгийн газрын нийт өрийн багцын 65.2 хувийг бүрдүүлж байна.

Монгол Улсын Засгийн газар тайлант онд 45 төслийн 9,109.5 тэрбум төгрөгийн ашиглаагүй зээлийн үлдэгдэлд 37.6 тэрбум төгрөгийн амлалтын хүү төлсөн байна.

Дотоод үнэт цаас: Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 688.5 тэрбум төгрөг буюу Засгийн газрын нийт өрийн багцын 1.9 хувийг эзэлж байна.

Дүрслэл 1. Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл

/тэрбум төгрөг/



Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлээс төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цаас 457.9 тэрбум төгрөг буюу 66.5 хувь, засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжих зорилгоор арилжаалсан үнэт цаас 133.5 тэрбум төгрөг буюу 19.4 хувь, Сайн хувьцаа хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цаас 97.1 тэрбум төгрөг буюу 14.1 хувийг тус тус эзэлж байна.

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн зорилтод “Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна” гэж заасны дагуу тайлант онд нийт 148.7 тэрбум төгрөгийн үнэт цаасыг Монголын хөрөнгийн бирж ХК-аар, орлогын дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор 150.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг хаалттай хэлбэрээр тус тус дамжуулан арилжаалсантай холбоотой Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл нэмэгдсэн байна.

Засгийн газрын өрийн баталгаа: Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 165.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 12.3 тэрбум төгрөгөөр буурчээ.

УИХ-ын 2024 оны “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” 17 дугаар тогтоолын дагуу Нийслэлийн ЗДТГ-аас олон улсын зах зээлд “Сэлбэ дэд төвийн орон сууцжуулалтын төсөл”-ийг санхүүжүүлэх зорилгоор 2024 онд 500.0 сая ам.долларын үнэт цаасанд Засгийн газрын өрийн баталгаа гаргасан.⁶

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өр төлбөр

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өр төлбөрийн үлдэгдэл 23,162.2 тэрбум төгрөг болж, 1,087.5 тэрбум төгрөгөөр өссөн.

Хүснэгт 29. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өр төлбөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн(+), Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	11,223,605.5	12,120,711.9	897,106.4	52.3
Богино хугацаат үнэт цаас	10,044.5	-	(10,044.5)	-
Богино хугацаат зээлийн өглөг	3,653,277.8	3,210,532.7	(442,745.1)	26.5
Өглөг	4,925,504.0	5,663,695.9	738,191.9	46.7
Урьдчилж орсон орлого	2,634,779.2	3,246,483.3	611,704.1	26.8
Урт хугацаат өр төлбөр дүн	10,851,135.9	11,041,518.9	190,383.0	47.7
Урт хугацаат үнэт цаас	3,786,601.1	3,378,680.2	(407,920.9)	30.6
Урт хугацаат зээл	7,064,534.8	7,662,838.7	598,303.9	69.4
Дүн	22,074,741.4	23,162,230.8	1,087,489.4	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн үлдэгдлээс урт хугацаат өр төлбөр 11,041.5 тэрбум төгрөг буюу 47.7 хувь, богино хугацаат өр төлбөр 12,120.7 тэрбум төгрөг буюу 52.3 хувийг тус тус эзэлж байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 190.3 тэрбум төгрөгөөр, богино хугацаат өр төлбөр 897.1 тэрбум төгрөгөөр өсөхөд дараах материаллаг өөрчлөлтүүд голлон нөлөөлжээ. Тухайлбал:

- “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн урт хугацаат өр төлбөр 355.6 тэрбум төгрөгөөр өссөн нь газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн хүрээнд хийгдэж буй бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнд “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК болон “Эрдэнэс Монгол” ХХК-аас олгосон урт хугацаат хөрөнгө оруулалтын зээлтэй холбоотой;
- “Тавантолгой төмөр зам” ХХК нь Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Хятадын төмөр замын барилгын гүүрийн инженерийн товчоо групп ХХК, “Эрдэнэс тавантолгой” ХК-тай байгуулсан гэрээний дагуу авсан санхүүжилтээс шалтгаалж урт хугацаат зээлийн өглөг 262.0 тэрбум төгрөгөөр өссөн;
- “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн өр төлбөр 425.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь татварын өглөг 0.3 тэрбум төгрөг, мөн тайлант хугацаанд уул уурхайн бүтээгдэхүүний арилжаанд оролцох журмын дагуу арилжаанд шалгарсан оролцогчдын 726.4 тэрбум төгрөгийн дэнчингийн битүүмжилтэй холбоотой байна;
- “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК нь 2025 оны 7 дугаар сард олон улсын зах зээлд 8.5 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай үнэт цаас арилжаалж 500.0 сая ам.долларын эх үүсвэр бүрдүүлсэн;
- “Улаанбаатар хөгжлийн корпорац” ХК-ийн өр төлбөр нэмэгдсэн нь охин компани болох “Улаанбаатар Энержи” ХХК-ийн “Батарей хураагуурын станц” төслийн санхүүжилт 286.2 тэрбум төгрөг;
- “Сэлбэ хорин минутын хот корпорац” ХК-ийн өр төлбөр 293.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь “Сэлбэ дэд төв” төслийн санхүүжилтийг захиалагчаас дамжуулан

⁶ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.8-д заасны дагуу аймаг, нийслэлийн өр болон Засгийн газрын өрийн баталгаа нь Засгийн газрын өрд тооцогддог тул тухайн үнэт цаасны үлдэгдлийг Засгийн газрын өрийн нэгтгэлд орон нутгийн өр хэсэгт тайлагнасан байна.

олгохоор хүлээн авч, эх үүсвэрийг гүйцэтгэлээр хаагдах хүртэлх хугацаанд нэмж бүртгэсэнтэй холбоотойгоор тус тус өссөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Засгийн газрын өрийн багцын 95.7 хувийг гадаад өр төлбөр, 65.2 хувийг гадаад зээл тус тус эзэлж байгаа нь валютын ханшийн алдагдал хүлээх эрсдэлтэй байна;
- Өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, дутуу тайлагнасан 66.6 тэрбум төгрөг /“Тавантолгой төмөр зам” ХХК 33.1 тэрбум төгрөг, “Монголын төмөр зам” ТӨХК 26.3 тэрбум төгрөг, “МИАТ ТӨХК” 1.8 тэрбум төгрөг, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК 2.8 тэрбум төгрөг, “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК 0.4 тэрбум төгрөг, “Мон-Атом” ХХК 1.0 тэрбум төгрөг, “Мэдээлэл технологийн үндэсний парк” ТӨААТҮГ 0.8 тэрбум төгрөг, бусад 0.4 тэрбум төгрөг/;
- “Тавантолгой төмөр зам” ХХК нь хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн шийдвэргүйгээр арилжааны банканд захиалагчийн хяналтын орлого, төслийн гүйцэтгэлийн баталгааг байршуулсан 79.6 тэрбум төгрөгийн хадгаламжийг барьцаалан салбар төмөр замын төслийн бүтээн байгуулалтыг гүйцэтгэж буй “Монголын төмөр зам” ТӨХК-д 78.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үүнээс “Тээвэр хөгжлийн банк” ХК-д байршуулсан хадгаламж барьцаалсан зээлийн үндсэн төлөлт, хүүгийн төлбөрийг төлж чадаагүйн улмаас барьцааг суутгуулсан;
- “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК нь Турбоагрегат №1-4-ийн шинэчлэл төслийг хийх зорилгоор “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-тай 2024 онд 7 жилийн хугацаатай байгуулсан /ЗГ-ДЦС-3 2024-01 дугаар/ гэрээний дагуу 70.6 сая евро буюу 260.1 тэрбум төгрөгийн урт хугацаат зээл авснаас нийт 67.1 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөртэй болсон;
- “Шивээ-Овоо” ХК нь толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК-аас жилийн 8.4-13.0 хувийн хүүтэй 135.9 тэрбум төгрөгийн зээл авсан бөгөөд тайлант хугацаанд 8.2 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөрийн үлдэгдэлтэй байна. Зээлийн хүүгийн төлбөрийн үлдэгдэл хуримтлагдсан нь байгууллагын санхүүгийн зардал болон өр төлбөрийн дарамтыг нэмэгдүүлэх, улмаар төлбөрийн чадвар муудах, санхүүгийн тогтвортой байдал алдагдах эрсдэл үүсгэж байна;
- “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн урт өглөгийн үлдэгдэл тайлант оны эцэст 1,296.0 тэрбум төгрөгт 85.6 байна;
- “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь “Эрчим хүчний төсөл 2”-ын хүрээнд авсан зээлийн тухайн онд төлөх үндсэн зээлийн төлбөр 4.6 тэрбум төгрөгийг төлөөгүй, хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөр үүсгэсэн;
- “Эрчимт Монгол” ТӨХХК-ийг Засгийн газрын 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн “Төрийн өмчит компанийг татан буулгах тухай” 91 дүгээр тогтоолоор татан буулгасан боловч үйл ажиллагааны зардлаа санхүүжүүлэх зорилгоор “ХААН банк” ХК-тай 1.9 тэрбум төгрөгийн ЗШГ25/28 тоот зээлийн шугамын гэрээг байгуулан тайлант оны эцэст 1.3 тэрбум төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Төсөвт байгууллагын өр төлбөр

Төсөвт байгууллагын өр төлбөрийн үлдэгдэл 1,368.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 46.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 30. Төсвийн байгууллагын нийт өр, төлбөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өссөн (+), Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	1,252,039.3	1,300,833.8	48,794.5	95.0
Богино хугацаат зээлийн өглөг	128.4	506.1	377.7	-
Өглөг	1,061,594.7	1,215,742.3	154,147.6	93.5
Урьдчилж орсон орлого	190,316.2	84,585.4	(105,730.8)	6.5
Урт хугацаат өр төлбөр дүн	70,427.0	67,998.1	(2,428.9)	5.0
Дүн	1,322,466.3	1,368,831.9	46,365.6	100.0
Үүнээс, ТЕЗ-ийн төрлөөр				
УТЕЗ	1,172,848.2	1,113,428.2	59,420.0	81.3
ОНТЕЗ	149,618.1	255,403.7	(105,785.6)	18.7
Дүн	1,322,466.3	1,368,831.9	46,365.6	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсөвт байгууллагын өр төлбөрөөс улсын ТЕЗ 1,113.4 тэрбум төгрөг буюу 81.3 хувийг, орон нутгийн ТЕЗ 255.4 тэрбум буюу 18.7 хувийг тус тус эзэлж байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд ЭМС 220.9 тэрбум төгрөг, ХЗДХС 261.8 тэрбум төгрөг, ХХААХҮС 180.4 тэрбум төгрөг, ЗТС 76.1 тэрбум төгрөг, БОУАӨС 80.5 тэрбум төгрөг, БС 54.5 тэрбум төгрөг, ХББОСС 38.6 тэрбум төгрөг, АТГ 22.7 тэрбум төгрөг, МУЕС 24.7 тэрбум, ЗГХЭГ 23.0 тэрбум төгрөг, ГБХНХС 20.2 тэрбум төгрөг, ЭХС 19.2 тэрбум төгрөг, Сангийн сайд 18.3 тэрбум төгрөг, БХС 11.2 тэрбум төгрөг, Нийслэл 108.6 төгрөг, Орхон 13.7 тэрбум төгрөг, Дорноговь 12.3 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 114.2 тэрбум төгрөг байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Нийслэл 50.0 тэрбум төгрөг, ЗТС 17.8 тэрбум төгрөг, ЭЗХС 0.2 тэрбум төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

- Өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, зөрүүтэй тайлагнасан, бүртгэлд тусгаагүй зэрэг нийт 10.4 тэрбум төгрөг /ЭМС 3.0 тэрбум төгрөг, Нийслэл 2.2 тэрбум төгрөг, УУХҮС 1.1 тэрбум төгрөг, ХХААХҮС 0.6 тэрбум төгрөг, БС 0.6 тэрбум төгрөг, БОУАӨС 0.4 тэрбум, бусад ТЕЗ 2.5 тэрбум төгрөг/;
- Төсвийг зохистой удирдаагүй, өр төлбөр үүсгэсэн нийт 16.9 тэрбум төгрөг /БС 7.5 тэрбум төгрөг, ЭМС 2.6 тэрбум төгрөг, МУШС 1.7 тэрбум төгрөг, ЗГХЭГ 0.5 тэрбум төгрөг, ХЗДХС 2.0 тэрбум төгрөг, ЦХИХХС 0.4 тэрбум төгрөг, АҮЭБС 0.2 тэрбум төгрөг, Нийслэл 0.1 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 1.9 тэрбум төгрөг/.

Нийгмийн даатгалын сангийн өр төлбөр

Нийгмийн даатгалын сангийн нийт өр төлбөрийн үлдэгдэл 146.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 57.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 31. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	89,138.1	146,298.0	57,159.8	100.0
Өглөг	37,431.6	76,636.4	39,204.8	52.4
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.1	0.2	0.1	-
Зээлийн хүүгийн өглөг	-	20.4	20.4	-
Бусад өглөг	37,431.5	76,615.9	39,184.4	52.4
Байгууллагад төлөх өглөг	10,698.8	10,347.7	(351.1)	7.1
Хувь хүмүүст төлөх өглөг	25,834.2	65,393.8	39,559.6	44.7
Дансны өглөг /ТӨҮГ/	898.5	874.4	(24.1)	0.6
Урьдчилж орсон орлого	51,706.5	69,661.5	17,955.0	47.6
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	51,706.5	69,661.5	17,955.0	47.6
Дүн	89,138.1	146,298.0	57,159.8	100.0

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос 57.2 тэрбум төгрөгөөр өссөн нь ЭМДЕГ-т төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 7.7 тэрбум төгрөгийн өглөг, ажилгүйдлийн даатгалын сангаас хувь хүмүүст олгох 39.2 тэрбум төгрөгийн өглөг нэмэгдсэнээс голлон нөлөөлжээ.

Урьдчилж орсон орлого дансанд сайн дурын даатгуулагч, ажил олгогч, улсын төсвөөс хариуцан төлдөг малчин, туслах малчин болон 3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн нийгмийн даатгалын шимтгэлийг урьдчилж төлсөн нийт 69.7 тэрбум төгрөг бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- СБД-ийн НДС-нд 0.03 тэрбум төгрөгийн эзэн холбогдогчгүй өглөгийн үлдэгдэлтэй;
- Олон жилийн насжилттай 0.2 тэрбум төгрөгийн өглөгийг буцаан олгох арга хэмжээ аваагүй, тайлант онд 0.4 тэрбум төгрөгийн өглөг үүсгэсэн /Булган аймгийн НДС 0.02 тэрбум төгрөг, БГД-ийн НДС 0.05 тэрбум төгрөг, БЗД-ийн НДС 0.02 тэрбум төгрөг төгрөг, Төвийн аймгийн НДС 0.3 тэрбум төгрөг/.

Эрүүл мэндийн даатгалын сангийн өр төлбөр

Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт өр төлбөрийн үлдэгдэл 198.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 118.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 32. Эрүүл мэндийн даатгалын сангийн өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	316,851.4	198,392.0	(118,459.4)
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	316,838.6	198,390.9	(118,447.7)
Байгууллагад төлөх өглөг	1.4	-	(1.4)
Хувь хүмүүст төлөх өглөг	4.7	-	(4.7)
Урьдчилж орсон орлого	6.7	1.1	(5.6)
НИЙТ ДҮН	316,851.4	198,392.0	(118,459.4)

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт өр төлбөрийн үлдэгдэл 118.5 тэрбум төгрөгөөр буурсан нь архаг өвчлөлөөс бусад нэн шаардлагатай бус тусламж, үйлчилгээг тодорхой түвшинд хязгаарлах, мөн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас тусламж, үйлчилгээг худалдан авах зэрэг арга хэмжээ авснаас шалтгаалжээ.

Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөгийн үлдэгдэлд улсын эмнэлэгт 118.3 тэрбум төгрөг, хувийн хэвшлийн эмнэлэгт 21.3 тэрбум төгрөг, рашаан сувилалд 0.2 тэрбум төгрөг, эмийн санд 26.4 тэрбум төгрөг, ӨЭМТ-д 1.9 тэрбум төгрөг, СЭМТ-д 30.3 тэрбум төгрөгийн өглөгтэй байгааг тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- ЭМДС нь сангийн орлогын эх үүсвэртэй уялдуулан эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрөл, төлбөрийн хэмжээг тогтоогоогүйгээс эм, эмнэлгийн байгууллагуудад 198.4 тэрбум төгрөгийн өртэй байгаа нь сангийн болон эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаа хэвийн явагдахад эрсдэл үүсэхээр байна.

5.11 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 72,369.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 7,855.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 33. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	7,867,789.1	9,539,132.9	1,671,343.8	21.3
Улсын төсвийн оруулсан хөрөнгө	5,103,635.3	6,769,644.7	1,666,009.4	21.2
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,764,153.8	2,769,488.2	5,334.4	0.1
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	7,548,982.6	8,136,250.1	587,267.5	7.5
Өмч /хувийн/ /ТӨҮГ/	15,495.7	15,503.3	7.6	-
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	11,256,095.0	11,256,095.0	-	-
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	18,396.5	18,563.7	167.2	-
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	10,063,086.0	10,747,368.7	684,282.7	8.7
Хуримтлагдсан үр дүн	20,063,740.9	24,388,554.5	4,324,813.6	55.1
Өмнөх үеийн үр дүн	2,727,034.9	15,821,547.8	13,094,512.9	166.7
Тайлант үеийн үр дүн	17,336,706.0	8,567,006.7	(8,769,699.3)	(111.6)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,510,105.8	8,098,373.0	588,267.2	7.5
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	154,699.3	153,830.2	(869.1)	-

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	217.6	272.6	55.0	-
Хяналтын бус хувь оролцоо	15,463.2	15,455.6	(7.6)	-
Цэвэр, хөрөнгө өмчийн дүн	64,514,071.7	72,369,399.6	7,855,327.9	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос 12.2 хувиар өссөн нь дараах шалтгаантай байна. Тухайлбал:

- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд: “Эрдэнэс Монгол” ХХК 3,472.4 тэрбум төгрөгийн тайлант үеийн цэвэр ашигтай, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хөрөнгийн дахин үнэлгээний нөөц 507.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, тайлант онд 756.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай;
- Төсөвт байгууллагын хуримтлагдсан үр дүн: Нийслэлийн Замын хөгжлийн газар 439.0 тэрбум төгрөг, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 0.3 тэрбум төгрөг;
- Төсөл сангийн хуримтлагдсан үр дүн: Ирээдүйн өв сан 1,710.6 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын сан 923.3 тэрбум төгрөг, Хуримтлалын сан 603.0 тэрбум төгрөг, Тогтворжуулалтын сан 562.5 тэрбум төгрөг, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл 290.4 тэрбум төгрөг, Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл 231.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр зарим төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн зарласан ногдол ашиг болон өмнөх онуудад хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний барьцааны баталгааг давхардуулан бүртгэсэн, үндсэн хөрөнгийн элэгдлийг буруу тооцсон зэрэг нийт 4,242.2 тэрбум төгрөгөөр залруулж, өмнөх үеийн үр дүнг бууруулсан байна.

6. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АСУУДЛААРХ ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 5,257.0 тэрбум төгрөгийн 2,059 зөрчил илэрснээс 0.3 тэрбум төгрөгийн зөрчилд 73 төлбөрийн акт, 4,720.9 тэрбум төгрөгийн зөрчилд 857 албан шаардлага, 528.0 тэрбум төгрөгийн зөрчилд 1,090 зөвлөмж өгч, 7.8 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 54 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 39 албан шаардлага хүргүүлсэн.

6.1. УЛСЫН ТӨСӨВ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 5,140.0 тэрбум төгрөгийн 1,297 зөрчил илэрснээс 0.1 тэрбум төгрөгийн зөрчилд 25 төлбөрийн акт тогтоож, 4,664.8 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, таслан зогсоох 456 албан шаардлага, 7.2 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 31 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 20 албан шаардлага хүргүүлж, 467.9 тэрбум төгрөгийн зөрчилд 796 зөвлөмж өгсөн.

6.2. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 117.0 тэрбум төгрөгийн 762 зөрчил илэрснээс 0.2 тэрбум төгрөгийн зөрчилд 48 төлбөрийн акт тогтоож, 56.1 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 401 албан шаардлага, 0.6 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 23 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 19 албан шаардлага хүргүүлж, 60.1 тэрбум төгрөгийн зөрчилд 294 зөвлөмж өгсөн.

7. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

7.1 ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитад Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, НДС, ЭМДС-ийн санхүүгийн тайлан, улсын болон орон нутгийн 60 ТЕЗ-дын эрхлэх асуудлын хүрээний 6,792 төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсөл, хөтөлбөрийн нэгж санхүүгийн тайлангийн аудитад хамрагдахаас 3,671 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж /өөрчлөлтгүй 2,963, хязгаарлалттай 679, сөрөг 21, дүгнэлт гаргахаас татгалзсан 8/, 3,100 санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж, 21 байгууллага аудитад хамрагдаагүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 11,836.4 тэрбум төгрөгийн 13,442 зөрчил илэрснээс 142.9 тэрбум төгрөгийн зөрчилд 2,261 төлбөрийн акт, 7,564.8 тэрбум төгрөгийн зөрчилд 4,663 албан шаардлага, 3,948.1 тэрбум төгрөгийн зөрчилд 6,276 зөвлөмж, 173.0 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 224 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 213 албан шаардлага хүргүүлж, 7.6 тэрбум төгрөгийн 29 асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит

Улсын төсвийн 36 ерөнхийлөн захирагч, НДС, ЭМДС-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийснээс өөрчлөлтгүй 17, хязгаарлалттай 21 /ХААХХҮС, СС, БОУАӨС, ЗТС, НДСҮЗД, ЭХС, МУШС /ГХО/, ЗГХЭГ, ЭМС, ХББОСС, ГБХНХС, ССАЖЗС, БС, ЭМДС, ЦХИХХС, ХЭҮКД, ЦАУЗБУКД, ҮХЦД, АҮЭБС, МУШС, МУТШС бөгөөд ЭЗХС/ дүгнэлт өгсөн байна.

Аудитад улсын ТЕЗ-дын эрхлэх асуудлын хүрээний 4,145 төсвийн захирагч, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсөл, хөтөлбөрийн нэгжийн санхүүгийн тайлан хамрагдахаас 2,505 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж /Өөрчлөлтгүй 2,139 Хязгаарлалттай 354, Сөрөг 10, Санал дүгнэлт гаргахаас татгалзсан 2/, 1,629 санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж, 11 байгууллагыг тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй, татан буугдсан зэрэг шалтгаанаар аудитад хамруулаагүй.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 10,487.3 тэрбум төгрөгийн 8,803 зөрчил илэрснээс 7.8 тэрбум төгрөгийн зөрчилд 1,528 төлбөрийн акт тогтоож, 7,100.5 тэрбум төгрөгийн 2,894 зөрчилд албан шаардлага, 168.8 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 140 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 134 албан шаардлага хүргүүлж, 3,202.6 тэрбум төгрөгийн зөрчилд 4,225 зөвлөмж өгч, 7.6 тэрбум төгрөгийн 22 асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит

Орон нутгийн төсвийн 22 ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өөрчлөлтгүй 15, хязгаарлалттай 7 /Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говь-сүмбэр, Дундговь, Дорнод, Өмнөговь/ дүгнэлтийг өгсөн.

Аудитад орон нутгийн ТЕЗ-дын эрхлэх асуудлын хүрээний 2,647 төсвийн захирагч, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсөл, хөтөлбөрийн нэгжийн тайланг хамруулахаас 1,166 байгууллагад дүгнэлт гаргаж, /Өөрчлөлтгүй 824, Хязгаарлалттай 325, Сөрөг 11, Санал дүгнэлт гаргахаас татгалзсан 6/, 1,471 санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж, тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй, татан буугдсан зэргээс шалтгаанаар 10 байгууллагыг аудитад хамруулаагүй.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 558.0 тэрбум төгрөгийн 4,624 зөрчил илэрснээс 3.2 тэрбум төгрөгийн зөрчилд 731 төлбөрийн акт тогтоож, 322.1 тэрбум төгрөгийн зөрчилд 1,767 албан шаардлага, 4.2 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 84 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 79 албан шаардлага хүргүүлж, 228.5 тэрбум төгрөгийн зөрчилд 2,040 зөвлөмж өгч, 0.01 тэрбум төгрөгийн 7 асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

Бүрэлтэй Ажлын Өмчийн Санхүүгийн
Тайлан

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 791.0 тэрбум төгрөгийн 15 зөрчил илэрснээс 131.8 тэрбум төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 142.2 тэрбум төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 517.0 тэрбум төгрөгийн зөрчилд 11 зөвлөмж өглөө.

7.2 ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой 6,309.8 тэрбум төгрөгийн ашигтай 274 хуулийн этгээд, 1,041.4 тэрбум төгрөгийн алдагдалтай 298 хуулийн этгээд, ашиг, алдагдалгүй ажилласан 55 хуулийн этгээд, нийт 627 хуулийн этгээдийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 158 хуулийн этгээдийн санхүүгийн тайланг аудитад хамруулснаас 100 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 58 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн. /Өөрчлөлтгүй 45, Хязгаарлалттай 52, Сөрөг 3/

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 7,957.0 тэрбум төгрөгийн 900 зөрчил илэрч, 1.3 тэрбум төгрөгийн зөрчилд 129 төлбөрийн акт тогтоож, 5,349.4 тэрбум төгрөгийн зөрчилд 370 албан шаардлага хүргүүлж, 2,450.9 тэрбум төгрөгийн зөрчилд 378 зөвлөмж өгч, 150.6 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 23 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар 20 албан шаардлага хүргүүлж, 4.8 тэрбум төгрөгийн 3 асуудлыг шалгуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд нийт 13,773.8 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 8,657.6 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 5,116.2 төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

Цэвэр ашиг өмнөх оноос 3,890.8 тэрбум төгрөг буюу 43.2 хувиар буурсан нь уул уурхайн салбараас тэр дундаа нүүрсний экспортын хэт хамааралтай байдлаас шалтгаалсан байна.

Тайлант онд 84 төрийн өмчит хуулийн этгээд 6,033.4 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол 64 төрийн өмчит хуулийн этгээд 917.2 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 917.2 тэрбум төгрөгийн алдагдлын 82.4 хувийг “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК, “Тавантолгой түлш” ХХК, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК, “Таван толгой төмөр зам” ХХК, “МИАТ” ТӨХК, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ууд эзэлж байгаа нь тус компаниудын үйл ажиллагааны зардал өмнөх оноос 71.3 хувиар өссөн.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтот түвшний төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг дунд хугацаагаар төлөвлөн 16,689.6 тэрбум төгрөгөөр баталж, тухайн тайлант онд санхүүжих хөрөнгө оруулалтад гүйцэтгэлээр 2,664.3 тэрбум төгрөгийг зарцуулсан. Хуулийн этгээдүүдийн тухайн жилд санхүүжих төсөл арга хэмжээний зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлийг хянаж нэгтгэх, үр дүнг бодитой үнэлэх нэгдсэн зохицуулалтгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Бодлогын хэрэгжилт хангалтгүй, үр дүн гараагүй:

- Төрийн өмчит хуулийн этгээдүүдийн хувьцааг олон нийтэд нээлттэй санал болгож, арилжаалах явц удаашралтай⁷;

Дотоод хяналт хариуцлагатай холбоотой:

- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийг хянах, үнэлэх эрх зүйн зохицуулалт тодорхойгүй, хяналт хэрэгжүүлээгүй байна;
- “Эрдэнэс монгол” ХХК нь 31 хараат болон охин компанитайгаас зөвхөн 7 компанитай менежментийн үйлчилгээний гэрээ байгуулсан нь нэгдлийн хэмжээний охин, хараат компаниудад менежментийн үйлчилгээг нэгдсэн байдлаар жигд, хүртээмжтэй, үр дүнтэй үзүүлээгүй;
- Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд 10 ахмадын хороо ТББ, 54 эмийн эргэлтийн сан, 24 өрхийн эмнэлэг ББН-ийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нэгэн адил нэгтгэсэн байна.

Үйл ажиллагааны үндсэн чиг үүрэгт хамааралгүй ажилтай холбоотой:

- “Эрдэнэс Монгол” ХХК нь компанийн дүрэмдээ эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр зээл олгох, зээл авах, зээлийн санхүүжилтийн гэрээ байгуулах, баталгаа болон батлан даалт гаргах эрхийг тусган батлуулсан бөгөөд орлогын тогтвортой эх үүсвэргүй, алдагдалтай ажиллаж байгаа хараат, охин компаниудад зээлийн санхүүжилт олгож, зээлийн эргэн төлөлтийн эрсдэлийг нэмэгдүүлж, найдваргүй авлага үүсэх нөхцөлийг бүрдүүлж, өмнөх жилүүдэд олгосон зээлийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдөөгүй байхад тайлант онд дахин 6 компанид 18.7 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилт олгосон;
- “Эрдэнэс Тавантолгой” ХК нь Засгийн газрын шийдвэрээр “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК, “Тавантолгой төмөр зам” ХХК, “Монголын төмөр зам” ТӨХК-уудад урт хугацаатай зээл олгож, нийт 918.0 тэрбум төгрөгийн эргэн төлөлтийн эрсдэлтэй зээлийн авлага үүсгэсэн байна;
- Хуулийн этгээдийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй, нийгмийн шинж чанар бүхий төсөл хөтөлбөр, арга хэмжээнд нийт 108.3 тэрбум төгрөгийг зарцуулсан;
- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үндсэн чиг үүргээс гадуурх стратегийн дэд бүтцийн томоохон төслүүд болох Богдхан төмөр зам болон газрын тос дамжуулах хоолойн нийт 1,042.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д хариуцуулсан нь байгууллагын санхүүгийн тогтвортой байдал, засаглалын зарчим болон хувьцаа эзэмшигчдийн эрхийг зөрчиж, холбогдох хууль эрх зүйн шаардлагад нийцэхгүй шийдвэр гаргасан;
- “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ын улсын бүртгэлийн гэрчилгээгээр зөвшөөрөгдөөгүй, чиг үүрэгт заагдаагүй бүтцийн 7 нэгжийг цех хэлбэрээр, түүнд харьяалах 791 албан хаагчийг бүтцэд баталж, тайлант онд 16.6 тэрбум төгрөгийн алдагдлыг санхүүжүүлсэн нь үйлдвэрийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн.

Хувьцааны талаар:

- “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК нь охин компанийн ТУЗ-ийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй;
- “Эрдэнэс Тавантолгой” ХК нь иргэдийн нас баралт, харьяаллын өөрчлөлт, өв залгамжлалтай холбоотойгоор хувьцааны шилжилт, эрхийн хэрэгжилтийг зохицуулах эрх зүйн зохицуулалтгүйгээс 2019-2024 онд зарласан ногдол ашгаас нийт 145.2 тэрбум төгрөгийн ногдол ашгийг тараагаагүй, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй;
- “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2025 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын 1 дүгээр тогтоол, ТУЗ-ийн 4 дүгээр тогтоолын дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК нь тус компанийн 100 хувийн хувьцаа эзэмшигч болж, нийт 816.2 сая ширхэг хувьцааг 2,040.5 тэрбум төгрөгийн үнэлгээгээр эзэмшсэн байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас төслийн санхүүжилтэд олгосон нийт 3,283.9 тэрбум төгрөгөөс 1,346.7 тэрбум төгрөгийг хувьцаанд хөрвүүлсэн бөгөөд үлдсэн 1,937.2 тэрбум төгрөгийг гэрээний заалтын дагуу хувьцаанд бүрэн хөрвүүлээгүй, урьдчилгаа дансанд үлдэгдлээр бүртгэсэн.

Бондын өр төлбөртэй холбоотой:

- “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс силвер ресурс” ХХК-уудын 2020 онд Эрдэнэс-1 /Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийн үүргийг үнэт цаасаар төлөх зориулалтаар

⁷ Монгол Улсын Засгийн газрын 2024 – 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 3.1.2.4 Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ.

гаргасан/ бондыг 5 жилийн хугацаатай, жилийн 6 хувийн хүүтэйгээр гаргасан бөгөөд 2025 оны эцэст бондын өглөг 614.9 тэрбум төгрөг, хорогдуулаагүй хөнгөлөлт 235.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй хэвээр байна. Салхитын мөнгө-алтны үндсэн ордын ТЭЗҮ-д тусгагдсан ил уурхайн үйлдвэрлэлийн хүдрийн нөөц 2025 оны 9 дүгээр сард олборлож дууссан байна.

Эрх бүхий байгууллагаас гаргасан зарим шийдвэр нь бусад хууль тогтоомжтой нийцээгүй, үр дүн, уялдаа холбоог үнэлж тооцоогүй, зохих арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлээгүй, хуулийн этгээдийн ашигт ажиллагаа, хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхүйц байна. Тухайлбал:

- “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-ийн 2020 онд “Эрдэнэс Монгол” ХХК-тай 5 жилийн хугацаатай 550.0 тэрбум төгрөгийн баталгаа гаргах гэрээ байгуулсан. Гэрээний хугацаа 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр дуусгавар болсон ч “Эрдэнэс Монгол” ХХК нь 2024 оны эцэст үүргийн гүйцэтгэлийг хангаагүй 849.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Засгийн газрын 2025 оны 32 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдаагүй байхад “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК нь баталгааг тэнцлийн гадуурх данснаас шууд хасалт хийсэн байна;
- УИХ-ын 2024 оны 10 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эрх бүхий байгууллага ногдол ашиг хуваарилахаар шийдвэр гаргасан тохиолдолд төрийн өмчид ногдох ногдол ашгийн орлогоос “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний нэгдэлд хамаарах, төрийн өмчийн оролцоотой бусад аж ахуйн нэгжүүдийн хооронд үүссэн өр, авлагыг суутган тооцохоор тогтоосон ч хэрэгжилт хангагдаагүй. Тус тогтоолын хэрэгжилт хангагдаагүйгээс “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн санхүүгийн тайланд 2022-2023 оны төрд ногдох ногдол ашгийн 3,305.2 тэрбум төгрөгийн урт хугацаат өр төлбөр бүртгэлтэй байна.

Худалдан авах ажиллагаатай холбоотой:

- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 4,047.5 тэрбум төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 2,682.6 тэрбум төгрөгийн гэрээ байгуулж, худалдан авалт хийсэн байна. Худалдан авах ажиллагаанд шууд гэрээ байгуулсан, төсөвт өртгийг хуваан худалдан авалт хийсэн болон тендер шалгаруулалтын процесстэй холбоотой нийт 146.7 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн.

Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит

Төрийн аудитын байгууллагаас 394 хуулийн этгээдээс 253 хуулийн этгээдийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 141 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн. /Өөрчлөлтгүй 179, Хязгаарлалттай 66, Сөрөг 5, Дүгнэлт өгөхөөс татгалзсан 3/

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 158.8 тэрбум төгрөгийн 976 санхүүгийн зөрчил илэрч, 0.7 тэрбум төгрөгийн зөрчилд 138 төлбөрийн акт тогтоож, 111.7 тэрбум төгрөгийн зөрчилд 293 албан шаардлага хүргүүлж, 43.2 тэрбум төгрөгийн зөрчилд 524 зөвлөмж өгч, 3.2 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 20 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 19 албан шаардлага хүргүүлж, 2 асуудлыг шалгуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.

Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд нийт 2,365.9 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 2,213.7 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 152.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Тайлант онд 190 орон нутгийн өмчит хуулийн этгээд 276.4 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол 234 орон нутгийн өмчит хуулийн этгээд 124.2 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Тайлант оны нийт цэвэр ашгийн 78.5 хувийг “Тавантолгой” ХК, “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ, “Геодези, усны барилга байгууламжийн газар” ОНӨААТҮГ, “Орон сууцны корпорац” ОНӨААТҮГ, “Баянтээг” ТӨХК тус тус эзэлж байгаа бөгөөд 21.5 хувийг бусад хуулийн этгээдийн дүн эзэлж байна.

Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн ашигт ажиллагаанд “Тавантолгой” ХК 182.9 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь голлон нөлөөлжээ.

Тайлант оны нийт алдагдал 124.2 тэрбум төгрөгийн 9.6 хувийг Ус сувгийн удирдах газар, 5.4 хувийг Улаанбаатар хотын Орон сууц нийтийн аж ахуйн газар, 5.0 хувийг “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ-ын алдагдал тус тус эзэлж, бусад 231 хуулийн этгээд 80.0 хувийг эзэлж байна.

Орон нутгийн 22 төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 354 хуулийн этгээдийг хамруулсан түүвэр судалгаагаар тайлант онд 193 хуулийн этгээд нийт 1,435.1 тэрбум төгрөгийн орлого тайлагнасны 961.2 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвийн татаас, санхүүжилтээр бүрдүүлжээ. Мөн үйл ажиллагаа явуулаагүй 24 хуулийн этгээд байна.

7.3 ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСЛҮҮДИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 81 дүгээр тогтоол, Засгийн газрын 2025 оны “Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төслүүдийн үр ашиг, бүтээмжийг сайжруулах зарим арга хэмжээний тухай” 24 дүгээр тогтоолын дагуу төслүүдийн урсгал зардлыг бууруулах, төслийн хөрөнгийг үндсэн зориулалтаар нь ашиглах, төслийн нэгжүүдийн бүтцүүдийг оновчтой болгох, бүтээмжийг дээшлүүлэх чиглэлийн хүрээнд 46 төсөл хэрэгжүүлэх нэгжийг 17 нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, төслийн ажилтны 474 орон тоог, 204 болгож бууруулсан байна.

Тайлант онд хэлэлцээрийн түвшинд 18, шинэ 1, он дамжин хэрэгжих 93, дуусах 20, дууссан 3 нийт 135 төсөл, хөтөлбөр байна.

Төрийн аудитын байгууллага тайлант онд нийт 116 төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайланд аудит хийж, нийт 40 дүгнэлт гаргаснаас “Өөрчлөлтгүй” 23 дүгнэлт, “Хязгаарлалттай” 17 дүгнэлт өгч, 76 төсөл хөтөлбөрийг аудитын түүвэрт хамруулсан байна.

Хүснэгт 34. Төсөл, хөтөлбөрийн нэгжийн өөрчлөлттэй дүгнэлт

№	Төсөл, хөтөлбөрийн нэгж	Өөрчлөлттэй дүгнэлтийн төрөл
1	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл	
2	Инженер, технологийн дээд боловсрол төсөл	
3	Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл	
4	Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл	
5	Монгол Улсад COVID-19 Халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл	
6	Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл	
7	Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл	
8	Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл - /3787/	Хязгаарлалттай дүгнэлт
9	Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл	
10	Улаанбаатар хотын ногоон орон сууц төсөл /ЕСБХБ-тусламж/	
11	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл /МТХ/	
12	Ухаалаг засаг төсөл-II	
13	Хилийн үр бүтээмжийг сайжруулж тогтвортой худалдааг дэмжих төсөл	
14	Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариаланг дэмжих төсөл	
15	Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн төслийг хөгжүүлэх нь төсөл	
16	Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл	
17	Чойр Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35кВ-н дэд станц барих төсөл	

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 404.5 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0.01 тэрбум төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 39.1 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 41 албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 365.4 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 55 зөвлөмж өгсөн.

Засгийн газрын гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлсэн Сангийн ямаар дамжсан 135 төсөл, хөтөлбөрийг Шинэ сэргэлтийн бодлогын хөгжлийн чиглэлүүдэд нийцсэн эсэхийг ангилбал 28.2 хувийг нийгэм, 27.4 хувийг хот, хөдөө, 16.3 хувийг эрчим хүч, 9.6 хувийг ногоон хөгжил, 9.6 хувийг боомт, 6.7 хувийг аж үйлдвэр, 1.5 хувийг төрийн бүтээмж гэсэн чиглэлийг баримталсан байна.

Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх нийт 116 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 1,959.4 тэрбум төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэл 1,874.8 тэрбум төгрөг буюу 95.7 хувьтай байгаа нь өмнөх оноос 25.2 хувиар буурсан. Батлагдсан төсвийн 79.3 хувийг хөрөнгө

оруулалтын зардалд, 11.0 хувийг эргэн төлөгдөх цэвэр зээлд, үлдсэн 9.7 хувийг урсгал зардалд тус тус зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Хэрэгжиж дууссан 11 төсөл, хөтөлбөрийн 306.9 тэрбум төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг холбогдох байгууллагуудад шилжүүлээгүй, санхүүгийн тайланд бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэн үлдээсэн нь тайлагналын үнэн зөв байдал алдагдах, улмаар хөрөнгө үргүйдэх эрсдэл үүсгэсэн байна.
- Олон улсын хөгжлийн түнш, хандивлагч орон, олон улсын байгууллагуудаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний эх үүсвэрийг оновчтой тодорхойлон үр ашигтай хувилбарыг сонгож, хэлэлцээрийн дүнд хязгаарлалт тогтоох талаар хууль, тогтоомжид тусгайлан заасан зохицуулалтгүй.
- Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 404.5 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн нь өмнөх оноос 127.1 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд тайлант онд төсөл хэрэгжүүлэх нэгжийн тоог бууруулж 17 нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж болгох бүтцийн өөрчлөлт хийсэн байна.

7.4 ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Засгийн газрын 25 тусгай сангаас 21 тусгай сангийн санхүүгийн тайланд аудит хийж, тайлант онд 4 тусгай сан /Хөгжлийн сан, Цагдаагийн хөгжлийн сан, Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан, Спортыг дэмжих сан/ үйл ажиллагаа явуулаагүй тул аудитад хамрагдаагүй.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 147.8 тэрбум төгрөгийн 121 зөрчил илэрснээс 0.3 тэрбум төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт тогтоож, 130.1 тэрбум төгрөгийн зөрчилд 53 албан шаардлага, зөрчил гаргасан 5 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 2 санал хүргүүлж, 17.4 тэрбум төгрөгийн зөрчилд 57 зөвлөмж өгч, 1 асуудлыг шалгуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.

Аудитын илрүүлэлт:

Боловсролын зээлийн сан:

- Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр 2025-2026 оны хичээлийн жилд суралцах 258 оюутанд нийт 9.3 тэрбум төгрөгийг гэрээ байгуулаагүй зээл олгосон;
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/480, 2023 оны А/408 дугаар тушаалын дагуу 2024-2025 оны хичээлийн жилд гадаадад суралцаж байсан 7 суралцагч гэрээний үүргээ биелүүлээгүйгээс санхүүжилтийг зогсоосон боловч 1.1 тэрбум төгрөгийг тооцоо нийлээгүй, эргэн төлүүлэх графикийг хийгээгүй.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан:

- Өмнөх оны ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх шийдвэрийг тухайн төсвийн жилд багтааж аж ахуйн нэгжүүдэд олгоогүй, холбогдох журмыг зөрчин он дамжуулан 6.4 тэрбум төгрөгийг 108 аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлсэн.

Улсын авто замын сан:

- Нийт 4 гүйцэтгэгчтэй байгуулсан "Улсын чанартай авто зам, замын байгууламжид 2025 онд арчлалт, засварын ажил гүйцэтгэх" гэрээний урьдчилгаа төлбөр 4.4 тэрбум төгрөгийг гэрээнд заасан хугацаанд суутгаагүй байна.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан:

- ЖДҮХС-аас тайлант онд 324 жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд нийт 47.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгожээ. Үүнээс: 26 зээлдэгчийн 4.1 тэрбум төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн, 4 зээлдэгчийн 0.8 тэрбум төгрөгийн зээл хэвийн бус төлөвтэй байгаа бөгөөд тайлант онд нийт олгосон зээлийн 10.2 хувь нь чанаргүй зээлийг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.

7.5 ӨМНӨХ АУДИТЫН МӨРӨӨР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН

Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар Монгол Улсын Ерөнхий сайдад 6, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 3, Сангийн сайдад 3 зөвлөмж өгсөн, Монгол Улсын Ерөнхий сайдад 2, Сангийн сайдад 2, Эрчим хүчний сайдад 1, Зам тээврийн сайдад 1, нийт 6 албан шаардлага хүргүүлж, Сангийн сайдад 1, Эрүүл мэндийн сайдад 1, нийт 2 төлбөрийн акт тогтоосон. Аудитаар шийдвэрийн хэрэгжилт дунджаар 58.9 хувийн биелэлттэй байна. Тухайлбал:

- Монгол Улсын Ерөнхий сайдад өгсөн 4 зөвлөмж хэрэгжих шатандаа, 2 зөвлөмж, 2 албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй;
- Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад өгсөн 2 зөвлөмж хэрэгжих шатандаа, 1 зөвлөмж хэрэгжилт хангалтгүй;
- Сангийн сайдад өгсөн 3 зөвлөмж хэрэгжих шатандаа, хүргүүлсэн 2 албан шаардлагаас 1 албан шаардлага хэрэгжиж, 1 албан шаардлага хэрэгжилт хангалтгүй, 1 төлбөрийн акт бүрэн төлөгдсөн;
- Зам, тээврийн сайдад хүргүүлсэн 1 албан шаардлага хэрэгжилт удаашралтай;
- Эрчим хүчний сайдад хүргүүлсэн 1 албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй;
- Эрүүл мэндийн сайдад тогтоосон 1 төлбөрийн акт бүрэн төлөгдсөн.

8. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Монгол Улсын Ерөнхий сайдад 6, Сангийн сайдад 2, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдад 1, Төсвийн ерөнхийлөн захирагч нарт 2 зөвлөмжийг өглөө.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД-д:

- 1. Дүгнэлт:** Засгийн газрын санхүүгийн тайланд нэгтгэгдсэн 627 хуулийн этгээдээс төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 64 хуулийн этгээд 917.2 тэрбум төгрөгийн, орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой 234 хуулийн этгээд 124.2 тэрбум төгрөгийн алдагдалтай, өмнөх оноос нийт алдагдал 149.4 хувиар буюу 623.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь төрийн өмчийн үнэ цэнэ буурах, өр төлбөр нэмэгдэх эрсдэлтэй байна.

Зөвлөмж: Алдагдалтай ажиллаж байгаа төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд чиг үүргийн шинжилгээ хийж, үйл ажиллагаа давхардалтай, олон жил алдагдалтай ажиллаж байгаа компаниудыг татан буулгах, нэгтгэх, засаглал, ил тод байдлыг сайжруулах, нээлтэй хувьцаат компани болгон өөрчлөх, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлэх.

- 2. Дүгнэлт:** Эрх бүхий байгууллагуудаас төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн бие даасан байдалд нөлөөлөхүйц, хууль, эрх зүйн орчинтой уялдаагүй шийдвэр гаргаж, үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй, нийгмийн шинж чанартай төсөл, арга хэмжээнд 1,151.0 тэрбум төгрөгийг санхүүжүүлсэн нь хуулийн этгээдүүдийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, үйлдвэрлэлийн өртөг, зардлыг нэмэгдүүлэх нөхцөлийг үүсгэж байна.

Зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн санхүүгийн тогтвортой байдал, ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, компанийн үндсэн чиг үүрэгт хамааралгүй хандив тусламж, түүнтэй адилтгах, хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагааг санхүүжүүлэх гэнэтийн шийдвэр гаргахгүй байх.

- 3. Дүгнэлт:** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд албан тасалгааны зориулалттай байр талбай хүрэлцээгүйгээс нийт 596 түрээсийн гэрээ байгуулж, түрээсийн төлбөрт 36.1 тэрбум төгрөг, ашиглалтын зардалд 11.1 тэрбум төгрөг төлж, үүнээс 1м.кв талбайн түрээсийн төлбөрийн дээд хязгаар 50,000.00 төгрөгөөс дээш үнийн дүнгээр 61 түрээсийн гэрээ байгуулж, түрээсийн төлбөр, ашиглалтын зардалд 16.3 тэрбум төгрөгийг зарцуулсан нь төрийн өмчийн ашиглалт, хуваарилалт, зохицуулалтын үр ашиг хангалтгүй, нэгдсэн бодлого дутагдалтай байгааг илтгэж байна.

Зөвлөмж: Төрийн өмчийн байр талбайг бусдад түрээслэхдээ төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд нэн тэргүүнд түрээслүүлэх, төрийн өмчит хуулийн этгээд бусдаас байр талбай түрээслэхдээ түрээсийн төлбөрийн дээд хязгаарт багтаасан эсэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хянаж, түрээслэх зөвшөөрөл олгох тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллах.

- 4. Дүгнэлт:** Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн “Чингис хаан банк” ХХК, “Үндэсний хөрөнгө оруулалтын банк” ХХК-д байгаа мөнгөн хөрөнгийн үлдэгдэл болон “Капитал банк” ХХК дахь эрх хүлээн авагчаас авах нийт 376.6 тэрбум төгрөгийн авлагаас 132.3 тэрбум төгрөгийг барагдуулж, 244.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй, 61.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг борлуулах үйл ажиллагаа удаашралтай байгаа нь сангийн хөрөнгийн бүрдүүлэлтэд эрсдэл үүсгэж байна.

Зөвлөмж: Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн “Чингис хаан банк” ХХК, “Үндэсний хөрөнгө оруулалтын банк” ХХК-д байгаа мөнгөн хөрөнгийн үлдэгдэл болон “Капитал банк” ХХК дахь эрх хүлээн авагчаас авах авлага барагдуулалтыг төлөвлөгөө гарган эрчимжүүлэх, хүлээн авсан хөрөнгийг мэргэжлийн байгууллагаар үнэлүүлсний үндсэн дээр худалдан борлуулах үйл ажиллагааг олон

нийтэд ил тод, нээлттэй байдлаар зохион байгуулж, сангийн мөнгөн хөрөнгийг бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллах.

- Дүгнэлт:** Гадаад дамжуулан зээлээс эргэн төлөлт хангалтгүй 217.0 тэрбум төгрөг, тооцоо нийлэх боломжгүй 106.7 тэрбум төгрөг, нийт 323.7 тэрбум төгрөгийн авлага бүрэн барагдахгүй байх эрсдэлтэй байна.

Зөвлөмж: Эргэн төлөлт хангалтгүй, тооцоо нийлэх боломжгүй авлагын үлдэгдлийг барагдуулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлж, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, цаашид олон жилийн насжилттай авлага үүсэхээс урьдчилан сэргийлж харилцагч талын санхүүгийн чадавхыг үнэлж, хяналт тавих.

- Дүгнэлт:** Улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 11,836.4 тэрбум төгрөгийн зөрчил илэрч өмнөх оноос 2,544.4 тэрбум төгрөгөөр буюу 27.4 хувиар өссөн нь санхүүгийн сахилга бат, хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт, хариуцлага хангалтгүй, аудитын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой байна.

Зөвлөмж: Төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн аудитын шийдвэрийн хэрэгжилтэд анхаарч, аудитын шийдвэрийг хангалтгүй хэрэгжүүлсэн төсвийн ерөнхийлөн захирагчид хариуцлага тооцох, цаашид төсөв захирагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тусгаж, Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангаж, төсөв, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх.

САНГИЙН САЙД-д:

- Дүгнэлт:** Засгийн газрын өрийн багцын 95.7 хувийг гадаад өр төлбөр, 65.2 хувийг гадаад зээл тус тус эзэлж байгаа нь валютын ханшийн алдагдал хүлээх эрсдэлтэй байна.

Зөвлөмж: Өрийн удирдлагын стратегид тусгасны дагуу өрийн бүтцийг хянан удирдаж, гадаад өрийн эзлэх хувь, ханшийн алдагдлыг бууруулах.

- Дүгнэлт:** Төсвийн зарлагын эх үүсвэрийг нөхөж өглөг үүсгэсэн дүнг өмнөх оноос 193.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг бууруулж тайлагнасан.

Зөвлөмж: Төрийн сангийн нэгдсэн дансны мөнгөн хөрөнгийн удирдлагын хүрээнд улсын төсвийн ерөнхийлөн захирагчдад өглөг үүсгэсэн дүнг үе шаттайгаар бууруулах арга хэмжээ авах.

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД-д:

- Дүгнэлт:** Тайлант онд өссөн дүнгээр 88.0 тэрбум төгрөгийн 8,175 (давхардсан тоогоор) программ хангамж /лиценз/-ыг санхүүгийн тайланд 21.3 тэрбум төгрөгөөр бууруулж, 66.7 тэрбум төгрөгөөр бүртгэсэн, программын хөгжүүлэлт, лиценз сунгах үйлчилгээний зардалд 10.3 тэрбум төгрөг зарцуулснаас урсгал зардлын төсвөөс 3.5 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зардлын төсвөөс 6.8 тэрбум төгрөгийг тус тус санхүүжүүлсэн байна.

Зөвлөмж: Төсөв захирагч бүр тус тусдаа, хоорондоо уялдаагүй программ хангамж хөгжүүлэх зардал гаргаж байгааг хязгаарлаж, программ хангамжийг хөгжүүлэх цахим хөгжлийн нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ нарт:

- Дүгнэлт:** Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт 404.5 тэрбум төгрөгийн зөрчил нь өмнөх оноос 127.1 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд тайлант онд төслийн урсгал зардлыг бууруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхээр төслийн нэгжийн тоог 17 нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж болгон бүтцийн өөрчлөлт хийсэн ч төсвийн ерөнхийлөн захирагчдаас тавих дотоод хяналт хангалтгүй хэвээр байна.

Зөвлөмж: Төсөл хэрэгжүүлэгч байгууллага өөрийн хариуцах гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, төсөл хөтөлбөрийн нэгжийн үйл ажиллагаа, санхүүжилт зарцуулалтад тавих дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлж, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг бууруулах.

- 2. Дүгнэлт:** Төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудад ашиглаж буй нягтлан бодох бүртгэлийн программ хангамж нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын өөрчлөлт, шинэчлэл болон холбогдох журам, зааврын шаардлагын хэрэгжилтийг хангаж байгаа эсэхэд хяналт хангалтгүй байна. Үүнээс шалтгаалж бүртгэл, тайлагналд зөрүү үүсэх, санхүүгийн тайлан бэлтгэхэд хүндрэлтэй нөхцөл байдал бий болох эрсдэлтэй байна.

Зөвлөмж: Байгууллагад ашиглаж буй нягтлан бодох бүртгэлийн программ хангамжид нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын өөрчлөлт, шинэчлэлийг тусгаж, холбогдох журам, зааврын дагуу санхүүгийн тайлан боловсруулах, тайлагнах боломжийг бүрэн хангаж байгаа эсэхэд хяналт хэрэгжүүлж ажиллах.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А164

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Монгол Улсын Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан”-г нэгдүгээр хавсралтаар, аудитаар тогтоосон төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газар, Сангийн яаманд тус тус хүргүүлэхийг Санхүүгийн аудитын газар (Н.Цэвэлмаа)-т даалгасугай.

3.Аудитаар тогтоосон төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлага, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд (Н.Учрал), Сангийн сайд (З.Мэндсайхан) нарт тус тус зөвлөсүгэй.

4.Аудитын тайланг Монгол Улсын Их Хурал болон холбогдох байнгын хороодоор хэлэлцүүлэх, бэлтгэл ажлыг хангахыг Санхүүгийн аудитын газар (Н.Цэвэлмаа)-т, аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар (Ч.Цэвэгдорж)-т тус тус үүрэг болгосугай.

5.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын баримтыг хадгаламжийн нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг Санхүүгийн аудитын газар (Н.Цэвэлмаа)-т үүрэг болгосугай.

6.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (Ж.Ариунболд)-д даалгасугай.



С.МАГНАЙСҮРЭН

Z:\Tushaal\2026\EA-In A Tushaal\0609 SAG-2.Docx

1526010253

Монгол Улсын Ерөнхий аудиторов
2026 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн
А/64 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТААР ТОГТООСОН ТӨЛБӨРИЙН АКТ,
ХҮРГҮҮЛСЭН АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ

Д/д	Хариуцагч байгууллага	Гаргасан шийдэл	Зөрчлийн утга	Зөрчлийн дүн /сая төгрөг/
1	Сангийн яам	Төлбөрийн акт	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Ирээдүйн өв санд 2025 онд хуваарилсан дүнгээс 131,712,888,591.00 төгрөгийг тус сангийн дансанд шилжүүлээгүй өглөгөөр тайлагнасан байна.	131,712.9
2	Сангийн яам	Төлбөрийн акт	Төрийн сангийн нэгдсэн дансанд эзэн холбогдогч нь тодорхойгүй нийт 117,724,035.00 төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байршиж байна.	117.7
3	Сангийн яам	Албан шаардлага	Дамжуулан зээлийн 27 аж ахуй нэгжид 1991-1994 онд гэрээ байгуулж олгосон 126,463,798,475.00 төгрөгийн авлага шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болсон боловч холбогдох арга хэмжээг авч шийдвэрлээгүйгээс ханшийн зөрүүгээр тайлант онд 15,777,774,066.00 төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 142,241,572,541.00 төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.	142,241.6
4	Монгол Улсын Засгийн газар	Албан шаардлага	Өмнөх оны аудитаар нийт 12 зөвлөмж хүргүүлснээс хэрэгжих шатандаа 9, хэрэгжилт хангалтгүй 3, нийт зөвлөмжийн биелэлт 51.1 хувь, хавсралтад дурдсан 6 албан шаардлага хүргүүлснээс 1 албан шаардлага бүрэн хэрэгжсэн, 5 албан шаардлага хэрэгжилт хангалтгүй, нийт албан шаардлагын биелэлт 25.5 хувьтай байна. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт өмнөх оноос 18.9 хувиар буурсан нь түүнд тавих дотоод хяналт болон төсөв захирагч нарын хоорондын ажлын уялдаа хангалтгүй байгаатай холбоотой байна.	-
НИЙТ ДҮН				274,072.2

